

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

... оны ... сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан журмыг төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Б.Болормаа/-т, Төрийн сангийн газар /Б.Цогбадрах/-т тус тус үүрэг болгосугай.

3.Төсвийн байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг энэхүү тушаалаар батлагдсан заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягтыг баримтлан хүлээж авахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЖАВХЛАН

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАГАЖ МӨРДӨХ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1.Төсвийн байгууллагын үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд тусгаж, санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт (цаашид УСНББОУС гэх)-д нийцүүлэн үнэн зөв бэлтгэхэд энэ журмын зорилго оршино.

1.2.Энэ журмаар зохицуулаагүй нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг бүртгэхдээ Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг дагаж мөрдөнө.

1.3.Төсвийн байгууллага нь энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан “Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Санхүүгийн тайлангийн маягт”, гуравдугаар хавсралтаар баталсан “Дансны жишиг жагсаалт”-ыг тус тус дагаж мөрдөнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ОРЛОГО

2.1.Орлого гэж байгууллагын хувь нийлүүлэгчдийн хувь оролцооноос бусад байдлаар цэвэр хөрөнгө буюу өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхын нийт орлогын гүйлгээ юм.

2.2.Татвар, тусламж болон шилжүүлгийн орлогыг УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого дагуу, татварын бус орлогыг УСНББОУС 9 Арилжааны ажил гүйлгээний орлого-ын дагуу бүртгэнэ.

2.3.Арилжааны бус ажил гүйлгээ гэж байгууллага нь ижил үнэ цэнтэй зүйлийг шууд өгөхгүйгээр нөгөө талаас хөрөнгө хүлээн авах, эсхүл хариуд нь ижил үнэ цэнтэй зүйлийг шууд авахгүйгээр нөгөө талд хөрөнгө өгөх ажил гүйлгээг хэлнэ.

2.4.Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөн арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн нөөцийн орлогын гүйлгээг тэрхүү орлогын гүйлгээтэй холбоотойгоор өр төлбөрийг хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд орлого гэж хүлээн зөвшөөрнө.

2.5.Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр анх хэмжинэ. Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тухайн өдрөөр хөрөнгийг худалдан авах үнэ, эсхүл гэрээний үнэ байна.

2.6.Байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээний үр дүнд хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хөрөнгийн дүнтэй тэнцүү хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

2.7.Хэрэв арилжааны бус ажил гүйлгээнээс бий болох нөөцийн орлогын гүйлгээний хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өр төлбөрийг бууруулсан дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

2.8.Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг тухайн байгууллагын хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өсөлтийн дүнгээр хэмжинэ.

2.9.Төсвийн байгууллага татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг өөрийн дансаар хүлээж аваад, төвлөрүүлж байгаа бол татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

2.10.Татвар, нийгмийн даатгалын шимтгэл ногдох үйл явдал гарч тохиолдсон ба хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдсан тохиолдолд байгууллага нь уг татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хувьд хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

2.11.Татвар, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийг олж эзэмшсэн өдрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

2.12.Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг хүлээн зөвшөөрөхдөө төлбөрийн нэхэмжлэх, тайлан тооцоо, төлбөрийн даалгавар, урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэхэд тус тус үндэслэн бүртгэнэ.

(а) төлбөрийн нэхэмжлэх, ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгуулагчийн тооцооны дагуу татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг тодорхойлж, орлогыг хүлээн зөвшөөрөх үед:

Дт	Татварын авлага /нэр төрлөөр/, эсхүл Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага
Кт	Татварын орлого, эсхүл Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого /нэр төрлөөр/

Иргэн, байгууллага татвар, нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөн үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Татварын авлага /нэр төрлөөр/, эсхүл Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

(б) урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэхийн дагуу татвар төлөгч иргэн, байгууллага татвар, шимтгэлээ урьдчилан төлсөн үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Урьдчилж орсон орлого

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн ногдлыг тодорхойлсон өдрөөр орлогыг хүлээн зөвшөөрөх үед:

Дт	Урьдчилж орсон орлого
Кт	Татварын орлого /нэр төрлөөр/, эсхүл Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого

(в) татварыг төлбөрийн даалгаврын дагуу ногдуулж, орлогыг хүлээн зөвшөөрөх үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Татварын орлого /нэр төрлөөр/

2.13.Татварын орлогын нэр, данс зөрсөн алдааг залруулах үед:

Дт	Татварын орлого /нэр төрлөөр/
Кт	Татварын орлого /нэр төрлөөр/

2.14.Тусламж, шилжүүлэгт татвараас бусад арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж ба үйлчилгээний чадавхын орох урсгал хамаарна.

2.15.Шилжүүлэг нь тусламж, Засгийн газрын дотоод шилжүүлэг, байгууллага хоорондын гүйлгээгээр хариу төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс бүрдэнэ.

2.16.Шилжүүлсэн нөөц нь хөрөнгийн тодорхойлолтыг ханган, хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлэх тохиолдолд шилжүүлгийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

2.17.Төсвийн байгууллага нь дээд шатны төсвийн эрх захирагчдаас шилжүүлгийг хүлээн авахад төсвийн санхүүжилтийн орлого дансанд бүртгэнэ.

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Төсвийн санхүүжилтийн орлого /нэр төрлөөр/

2.18.Төсвийн жилийн эцсийн зарцуулагдаагүй, улсын төсөвт төвлөрүүлсэн дансны үлдэгдлээс буцаан олгохоор тооцоо нийлэн баталгаажуулсан дүнг татаас, санхүүжилтийн авлага дансанд бүртгэнэ.

Дт Татаас, санхүүжилтийн авлага
Кт Төсвийн санхүүжилтийн орлого /нэр төрлөөр/

2.19.Олон улсын байгууллага, гадаад орны засгийн газар, бусад байгууллага, иргэдээс эргэн төлөгдөх нөхцөлгүй хүлээн авсан хөрөнгийг тусламжийн орлогоор бүртгэнэ.

(а) тусламжийг мөнгөн хөрөнгөөр хүлээн авах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Мөнгөн тусламжийн орлого

(б) тусламжийг бараа материалаар хүлээн авах үед:

Дт Бараа материал /нэр төрлөөр/
Кт Хөрөнгийн тусламжийн орлого

(в) тусламжийг үндсэн хөрөнгөөр хүлээн авах үед:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Хөрөнгийн тусламжийн орлого/хойшлогдсон орлого

Арилжааны ажил гүйлгээний орлого

2.20.Арилжааны ажил гүйлгээ гэж нэг байгууллага хөрөнгө болон үйлчилгээг хүлээн авах, эсхүл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ижил үнэ цэнтэй зүйлсийг нөгөө талд шууд өгөх ажил гүйлгээг хэлнэ. Арилжааны ажил гүйлгээний орлогод дараах төрлийн орлогууд хамаарна:

(а) үйлчилгээ үзүүлсний орлого;

(б) бараа борлуулсны орлого;

(в) хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтын орлого.

2.21.Орлогыг хүлээн авсан буюу хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

2.22.Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд үйлчилгээ үзүүлсний орлогыг хүлээн зөвшөөрнө.

(а) орлогын дүнг найдвартай хэмжиж чадах;

(б) ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавх нь тухайн байгууллагад орох нэлээд их магадлалтай байх;

(в) тухайн тайлангийн өдрөөрх уг ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг найдвартай хэмжиж чадах;

(г) тухайн ажил гүйлгээний хувьд гарсан өртөг зардал ба ажил гүйлгээг дуусган иж бүрэн болгоход гарах өртөг зардлыг найдвартай хэмжиж чадах.

2.23.Үйлчилгээ үзүүлэхдээ холбоотой ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй тохиолдолд нөхөн төлөгдөх зөвхөн зардлын хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

2.24.Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд бараа борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө.

(а).байгууллага нь барааны өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн;

(б).байгууллага нь тухайн борлуулсан барааны өмчлөл болон хяналт байхгүй болсон;

(в).орлогын дүнг найдвартай хэмжиж чадах;

(г).ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавх нь тухайн байгууллагад орох нэлээд их магадлалтай байх;

(д).ажил гүйлгээний гарсан, эсхүл гарах зардлыг найдвартай хэмжиж чадах.

2.25.Орлогоор хүлээн зөвшөөрсөн дүнгийн хувьд тодорхойгүй байдал үүссэн тохиолдолд уг үл цуглуулагдах дүн буюу нөхөн төлөгдөх магадлалгүй болсон дүнг анх хүлээн зөвшөөрсөн орлогыг бууруулж тохируулахгүй, харин зардал гэж хүлээн зөвшөөрнө.

2.26.Ирээдүйд үзүүлэх үйлчилгээ, нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг үйлчлүүлэгчээс урьдчилан хүлээн авсан бол урьдчилж орсон орлогоор бүртгэх ба бараа үйлчилгээг бодитой нийлүүлэх үед орлогоор хүлээн зөвшөөрнө.

2.27.Байгууллагын хөрөнгийг бусдад ашиглуулснаар үүсэх хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтын орлогыг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө:

(а).ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавх нь тухайн байгууллагад орох нэлээд их магадлалтай байх;

(б).орлогын дүнг найдвартай хэмжиж чадах.

2.28.Ажил, үйлчилгээний орлогыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) ажил, үйлчилгээг үзүүлээд орлогыг нэхэмжилсэн үед:

Дт	Бараа борлуулалт, ажил үйлчилгээний авлага
Кт	Төсвийн байгууллагын өөрийн орлого

(б) нэхэмжилсэн авлагыг хүлээн авах үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Бараа борлуулалт, ажил үйлчилгээний авлага

(г) төлбөртэй үйлчилгээний орлогыг урьдчилж хүлээн авах үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Урьдчилж орсон орлого

(д) ажлын гүйцэтгэл, эсхүл нийлүүлсэн бүтээгдэхүүнд үндэслэн урьдчилж орсон орлогын дүнг бууруулж, холбогдох орлогын дансанд бүртгэнэ:

Дт	Урьдчилж орсон орлого
Кт	Төсвийн байгууллагын өөрийн орлого

(е) байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг бүртгэхдээ:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Авлага
Кт Төсвийн байгууллагын нэмэлт орлого

2.29.байгууллагын борлуулсан барааны орлогыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) бараа материал борлуулах үед:

Дт Бараа борлуулалт, ажил үйлчилгээний авлага
Кт Төсвийн байгууллагын өөрийн орлого

Дт Бараа материалын зардал
Кт Бараа материал /нэр төрлөөр/

(б) нэхэмжилсэн авлагыг хүлээн авах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Бараа борлуулалт, ажил үйлчилгээний авлага

(в) бараа материалаас бусад хөрөнгийг дансны үнээс илүү үнээр борлуулах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Авлага
Кт Хөрөнгө борлуулсны олз
Кт Хөрөнгө /нэр төрлөөр/

2.30.Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтын орлогыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан цаг хугацаатай хувь тэнцүүлсэн сууриар хүүг хүлээн зөвшөөрнө.

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Хүүгийн авлага
Кт Хүүгийн орлого

(б) холбогдох гэрээний мөн чанарын дагуу олсон хэмжээгээр эрхийн шимтгэлийг хүлээн зөвшөөрнө.

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Бусад авлага
Кт Эрхийн шимтгэлийн орлого

(в) төлбөрийг хүлээн авах эрх үүссэн үед ногдол ашгийг хүлээн зөвшөөрнө.

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Ногдол ашгийн авлага
Кт Ногдол ашгийн орлого

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗАРДАЛ

3.1.Зардал гэж өмчлөлийн хуваарилалтаас үүссэн багасалтаас бусад байдлаар тухайн байгууллагын цэвэр санхүүгийн байдалд гарсан бууралт юм.

3.2.Зардлын онцлогийг харгалзан холбогдох УСНББОУС-ын шаардлагын дагуу зардлыг бүртгэнэ. Тухайлбал, арилжааны бус ажил гүйлгээтэй холбоотой зардлын хувьд УСНББОУС 23 *Арилжааны бус ажил гүйлгээний орлого*, арилжааны ажил гүйлгээтэй холбоотой зардлын хувьд УСНББОУС 9 *Арилжааны ажил гүйлгээний орлого*, хүүгийн зардлын хувьд УСНББОУС 5 *Зээлийн өртөг*, түрээсийн зардлын хувьд УСНББОУС 13 *Түрээс*, ажилтантай холбоотой зардлын хувьд УСНББОУС 39 *Ажилтны тэтгэмж*, үндсэн хөрөнгийн элэгдэл, үнэ цэнийн бууралт

болон бусад холбогдох зардлын хувьд УСНББОУС 17 *Үндсэн хөрөнгө*, УСНББОУС 21 *Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, УСНББОУС 26 *Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, биет бус хөрөнгийн хувьд УСНББОУС 31 *Биет бус хөрөнгө* зэрэг холбогдох стандартуудын шаардлагыг мөрдөнө.

3.3.Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал зардлыг хүлээн зөвшөөрнө.

3.4.Зардлыг төлсөн, эсхүл төлөхөөр хүлээгдэж байгаа мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжинэ.

Ажилтантай холбоотой зардал

3.5.Ажилтны цалин хөлс, олговрыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) цалингийн урьдчилгаа олгох үед:

Дт	Цалингийн урьдчилгаа
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(б) олгохоор тооцсон цалин хөлс, олговор:

Дт	Цалин хөлс, олговор
Кт	Цалингийн тооцоо

(в) цалингийн урьдчилгаа, суутгасан суутгалууд болон гарт олгох цалингийн дүнгээр:

Дт	Цалингийн тооцоо
Кт	Цалингийн урьдчилгаа
Кт	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр
Кт	ХХОАТ-ын өглөг
Кт	Цалингийн өглөг

(г) суутгасан татвар, шимтгэлийг төлөх үед:

Дт	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр
Дт	ХХОАТ-ын өглөг
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(д) цалин хөлс, олговрыг төлөх үед:

Дт	Цалингийн өглөг
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал

3.6.Байгууллагын төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг тооцоолох үед:

Дт	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл
Кт	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр

(б) нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг төлөх үед:

Дт	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бараа, ажил үйлчилгээний зардал

3.7.Тайлант үед хамаарах бараа, ажил үйлчилгээний зардлыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэхэмжлэхийг хүлээн авах үед:

Дт Бараа материал /нэр төрлөөр/, эсхүл Зардал /нэр төрлөөр/
Кт Дансны өглөг /нэр төрлөөр/

(б) нэхэмжилсэн өглөгийг төлөх үед:

Дт Дансны өглөг /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(в) байгууллагын хэрэгцээнд зориулан бараа материал зарцуулах үед:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Бараа материал /нэр төрлөөр/

(г) зардлыг урьдчилан төлөх үед:

Дт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(д) урьдчилж төлсөн зардлаас тухайн тайлант үед хэрэгжсэн үед:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/

Хөрөнгийн элэгдэл, хорогдуулгын зардал

3.8.Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна.

(а) үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн элэгдлийг бүртгэх үед:

Дт Элэгдлийн зардал
Кт Хуримтлагдсан элэгдэл

(б) биет бус хөрөнгийн хорогдуулгыг бүртгэх үед

Дт Хорогдуулгын зардал
Кт Хуримтлагдсан хорогдуулга

Хүүгийн зардал

3.9.Санхүүгийн хэрэглүүрт хамаарах хүүгийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) хүүгийн зардлыг хуримтлуулан тооцох үед:

Дт Хүүгийн зардал
Кт Хүүгийн өглөг

(б) хүүгийн төлбөрийг төлөх үед:

Дт Хүүгийн өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бусад зардал, гарз

3.10.Бусад зардал, гарзыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) зардлыг хуримтлуулах үед:

Дт Зардал /нэр төрлөөр/

Кт Дансны өглөг /нэр төрлөөр/

(б) хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг бүртгэх үед:

Дт Үнэ цэнийн бууралтын гарз

Кт Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

(в) найдваргүй авлагын нөөц байгуулах үед:

Дт Найдваргүй авлагын зардал

Кт Найдваргүй авлагын нөөц

(г) хөрөнгийг дансны үнээс бага үнээр борлуулах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө / Авлага

Дт Хөрөнгө борлуулсны гарз

Кт Хөрөнгө /нэр төрлөөр/

(д) хөрөнгийг данснаас хасах үед:

Дт Хөрөнгө данснаас хассаны гарз

Кт Хөрөнгө /нэр төрлөөр/

Нийгмийн хамгааллын зардал

3.11.Нийгмийн хамгааллын зардлыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) тэтгэвэр, тэтгэмж авагчдын бүртгэл, тогтоосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын хэмжээнд үндэслэн олгохоор тооцсон дүнгээр:

Дт Зардал /нэр төрлөөр/

Кт Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын өр төлбөр

(б) тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг олгосон үед:

Дт Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын өр төлбөр

Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Орлого, зарлагын нэгдсэн данс

3.12.Тайлант үеийн эцэст орлого, зардлын дансны үлдэгдлийг орлого, зардлын нэгдсэн дансанд хааж, үр дүнг тооцон хуримтлагдсан үр дүн дансанд хаалтын бичилт хийнэ.

(а) орлогын дансны хаалт:

Дт Орлого /нэр төрлөөр/

Кт Орлого, зарлагын нэгдсэн данс

(б) зардлын дансны хаалт:

Дт Орлого, зарлагын нэгдсэн данс

Кт Зардал /нэр төрлөөр/

(в) орлого болон зарлагын дансны зөрүүгийн хаалт:

Дт Орлого, зарлагын нэгдсэн данс

Кт Хуримтлагдсан үр дүн

Эсхүл:

Дт Хуримтлагдсан үр дүн

Кт Орлого, зарлагын нэгдсэн данс

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

4.1. Санхүүгийн хэрэглүүр нь нэг байгууллагын хувьд санхүүгийн хөрөнгө, нөгөө байгууллагын хувьд санхүүгийн өр төлбөр, эсхүл өмчийн хэрэглүүр үүсгэдэг аливаа гэрээ юм. Үүнд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, зээл, үнэт цаас, гадаад валютын форвард, своп хэлцэл гэх мэт санхүүгийн хэрэглүүрийг арилжаалах хэлцлүүд болон эдгээртэй адилтгах гэрээ, хэлцэл багтана.

4.2. Санхүүгийн хөрөнгөнд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, хөрөнгө оруулалт, санхүүгийн үүсмэл хэрэглүүр, тэдгээртэй ижил төстэй гэрээ багтана.

4.3. Санхүүгийн хөрөнгийг УСНББОУС 28 *Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга*, УСНББОУС 29 *Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*, УСНББОУС 30 *Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга*-ийн дагуу бүртгэнэ.

4.4. Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна:

(а) хэмжилтийн бүлгээр нь ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт, зээл ба авлага, борлуулах боломжтой;

(б) төрлөөр нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, өмчийн хөрөнгө оруулалт, бусад санхүүгийн хөрөнгө, санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт, санхүүгийн үүсмэл хэрэглүүр;

(в) хугацаагаар нь эргэлтийн (12 сараас бага хугацаатай) болон эргэлтийн бус (12 сараас дээш хугацаатай) гэж ангилна.

4.5. Байгууллага нь хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон үед санхүүгийн байдлын тайландаа санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

4.6. Санхүүгийн хөрөнгийн хэмжилт, толилуулга нь ангилал тус бүрд ялгаатай байдгийг доорх нэгтгэн харуулав:

д/д	Зээл ба авлага	Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших	Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих	Борлуулах боломжтой
Анхны хэмжилт	Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ
Ажил гүйлгээний өртөг	Анхны үнэлгээг нэмэгдүүлнэ	Анхны үнэлгээг нэмэгдүүлнэ	Анхны үнэлгээнд багтахгүй	Анхны үнэлгээг нэмэгдүүлнэ
Дараагийн тайлант үеийн хэмжилт	Хорогдуулсан өртөг	Хорогдуулсан өртөг	Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ
Дараагийн тайлант үеийн үнэлгээний өөрчлөлтийг бүртгэх	-	-	Ашиг, алдагдал	Цэвэр хөрөнгө/ өмч
Хорогдуулсан дүнг бүртгэх	Ашиг, алдагдал	Ашиг, алдагдал	-	-
Үнэ цэнийн бууралт	Ашиг, алдагдал	Ашиг, алдагдал	-	Ашиг, алдагдал

4.7. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжих ба үүнийг ажил гүйлгээний өртгөөр бууруулж бүртгэх эсэх нь түүний ангиллаас хамаарна.

4.8.Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хэрхэн хэмжих нь уг хэрэглүүрийн ангиллаас хамаарна.

(а).зээл ба авлага, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ;

(б).ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө болон борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж, тайлагнана.

4.9.Санхүүгийн хөрөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, олз, гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

ТАВДУГААР БҮЛЭГ

МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

5.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь кассад байгаа бэлэн мөнгө, харилцахад байгаа мөнгө, замд яваа мөнгө, мөнгөтэй адилтгах бусад хөрөнгөөс бүрдэнэ.

5.2.Мөнгөтэй адилтгах хөрөнгө гэж үнэ цэнийн өөрчлөлтийг маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, ихээхэн өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт юм.

5.3.Байгууллага нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг эзэмшиж, захиран зарцуулах эрх үүссэн үед хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

5.4.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжинэ.

5.5.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой орлогын гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

(а) дээд шатны төсвийн эрх захирагчдаас шилжүүлгийг хүлээн авах үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Төсвийн санхүүжилтийн орлого /нэр төрлөөр/

(б) татвар төлөгч иргэн, байгууллага татвараа төлөх үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Татварын авлага/ Татварын орлого/ Урьдчилж орсон орлого

(в) олон улсын байгууллага, гадаад орны засгийн газар, бусад байгууллага, иргэдээс тусламжаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө хүлээн авах үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Мөнгөн тусламжийн орлого

(г) бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг урьдчилж хүлээн авах үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Урьдчилж орсон орлого

(д) борлуулсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг хүлээн авах үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Төсвийн байгууллагын өөрийн орлого

(е) авлага төлөгдөх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Авлага /нэр төрлөөр/

(ё) зээл, үнэт цаас гаргах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Зээлийн өглөг/ Үнэт цаасны өглөг

5.6.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөтэй холбоотой зарлагын гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

(а) төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлэх үед:

Дт Төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(б) нэхэмжилсэн бараа, ажил үйлчилгээний төлбөрийг төлөх үед:

Дт Дансны өглөг /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(в) зардлыг урьдчилан төлөх үед:

Дт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(г) цалингийн урьдчилгаа олгох үед:

Дт Цалингийн урьдчилгаа
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(д) цалин хөлс, олговрыг олгох үед:

Дт Цалингийн өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(е) хүүгийн төлбөрийг төлөх үед:

Дт Хүүгийн өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(ё) өр төлбөрийг төлж барагдуулах үед:

Дт Өр төлбөр /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

ЗУРГААДУГААР БҮЛЭГ АВЛАГА

6.1.Авлага гэж зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээнийхээ төлбөрийг худалдан авагч, бусад харилцагч этгээдээс нэхэмжлэн авах мөнгөн дүнг хэлнэ.

6.2.Татвар, нийгмийн даатгалын шимтгэл ногдох үйл явдал тохиолдсон ба хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдсан тохиолдолд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг хүлээн зөвшөөрнө.

6.3.Байгууллага бараа, ажил үйлчилгээг нийлүүлсэн боловч төлбөрийг хараахан аваагүй үед төлөгдөөгүй дүнгээр авлага хүлээн зөвшөөрнө.

6.4.Авлагыг ирээдүйд хүлээн авахаар тооцсон цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн байдлын тайланд толилуулна.

6.5. Авлагын цэвэр боломжит үнэ цэнэ нь төлөгдөх боломжтой авлагын дүнгээр тодорхойлогдох ба гэрээнд заагдсан авлагын нийт дүнгээс найдваргүй гэж үзсэн, төлөгдөх боломжгүй авлагыг хассан дүн юм.

Найдваргүй авлага

6.6. Байгууллага арилжааны ажил гүйлгээний үр дүнд бий болсон авлагын үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын нөөцийг байгуулахдаа өмнөх жилүүдийн туршлагад үндэслэн авлагын эргэн төлөлтөд нөлөөлж болох доорх хүчин зүйлсийг харгалзан хувь хэмжээг тогтооно:

- (а) төлбөр хариуцагч этгээдийн санхүү, төлбөрийн чадвар;
- (б) гэрээний нөхцөлийг зөрчих магадлал;
- (в) төлбөр хариуцагч (хуулийн этгээд) татан буугдах, дампуурах боломж, эсхүл удирдлага, бүтэц өөрчлөгдөх нөхцөлүүд;
- (г) авлага нь төлөгдөх хуваарьт өдрөөс хойш 1 жилээс дээш хугацаанд хөдөлгөөн хийгдээгүй;
- (д) төлбөр хариуцагч гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байх бусад тохиолдол, нөхцөлүүд, тэдгээрт байгууллагын зүгээс авах арга хэмжээ.

6.7. Шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн төлөгдөх найдваргүй болсон авлагыг данснаас хасаж болно.

6.8. Арилжааны ажил гүйлгээний авлагыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) арилжааны ажил гүйлгээний үр дүнд үүссэн авлагыг бүртгэх үед:

Дт	Бараа борлуулалт, ажил үйлчилгээний авлага
Дт	Түрээсийн авлага
Дт	Бусад авлага
Кт	Орлого /нэр төрлөөр/

(б) авлага төлөгдөх үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Авлага /нэр төрлөөр/

(в) хүүгийн орлогыг хуримтлуулан бүртгэх үед:

Дт	Хүүгийн авлага
Кт	Хүүгийн орлого

(г) хуримтлуулсан хүү төлөгдсөн үед:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Хүүгийн авлага

6.9. Найдваргүй авлагыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) найдваргүй авлагын нөөцийг байгуулсан үед:

Дт	Найдваргүй авлагын зардал
Кт	Найдваргүй авлагын нөөц

(б) найдваргүй авлагын нөөцийг буцаах бичилт хийх үед тухайн тайлангийн үед хүлээн зөвшөөрсөн зардлыг бууруулна, эсхүл бусад олзоор бүртгэнэ:

Дт	Найдваргүй авлагын нөөц
Кт	Найдваргүй авлагын зардал/ Бусад олз

(в) найдваргүй авлагыг данснаас хасах үед:

Дт Найдваргүй авлагын нөөц
Кт Авлага /нэр төрлөөр/

(г) найдваргүй гэж данснаас хассан авлага эргэн төлөгдсөн үед:

Дт Авлага /нэр төрлөөр/
Кт Найдваргүй авлагын нөөц

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Авлага /нэр төрлөөр/

ДОЛООДУГААР БҮЛЭГ ӨМЧИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

7.1.Төсвийн байгууллага нь бусад аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хөрөнгө оруулалтыг Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгууллагын шийдвэр, эсхүл тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаал, шийдвэрт үндэслэн бүртгэнэ.

7.2.Байгууллага нь холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу мэдэгдэхүйц нөлөө үүссэн эсэх, хяналт болон хамтын хяналт тогтоосон эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр өмчийн хөрөнгө оруулалтыг өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалт, хамтын хяналттай байгууллага дахь хөрөнгө оруулалт, хяналтад байгаа байгууллага дахь хөрөнгө оруулалт гэж дараах байдлаар дөрөв ангилан, бүртгэнэ.

Эзэмшлийн хувь	0% - 20%	21% - 50%	0% - 50%	51% - 100%
Оролцоо	Маш бага, эсхүл нөлөөгүй	Мэдэгдэхүйц нөлөөтэй	Хамтын хяналт	Хяналтын оролцоотой
Хөрөнгө оруулалтын ангилал	Өмчийн хэрэглүүр (Санхүүгийн хөрөнгө)	Хараат байгууллага	Хамтын хяналтад байгаа байгууллага	Хяналтад байгаа байгууллага
Мөрдөх стандарт	УСНББОУС 28,29,30	УСНББОУС 36		УСНББОУС 35
Үнэлгээний арга	Бодит үнэ цэнэ, эсхүл өртөг	Өмчийн арга, бодит үнэ цэнэ, эсхүл өртөг		Бодит үнэ цэнэ, эсхүл өртөг

7.3.Бодит үнэ цэнийн арга нь хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр бүртгэх ба бодит үнэ цэнийн өсөлт, бууралтаар тохируулж бүртгэнэ.

7.4.Өртгийн арга нь хөрөнгө оруулалтыг өртгөөр бүртгэх ба үнэ цэнэ буурсан үед үнэлгээг бууруулан, тохируулж бүртгэнэ.

7.5.Өмчийн арга нь хөрөнгө оруулалтыг эхэлж өртгөөр хүлээн зөвшөөрсний дараа санхүүжигч байгууллагын цэвэр хөрөнгө дэх гарсан өөрчлөлтийг эзэмшлийн хувь оролцоогоор тохируулан бүртгэнэ.

7.6.Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэнэ:

Дт Өмчийн хөрөнгө оруулалт
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Өмчийн арга

7.7.Хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар бүртгэх үед:

(а) тайлант үеийн эцэст санхүүжигч байгууллага ашигтай ажилласан бол уг цэвэр ашгаас ногдох эзэмшлийн хувь оролцоогоор хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлнэ. Санхүүжигч байгууллагын ашгаас эзэмшлийн хувь оролцоогоор хүлээн зөвшөөрөх үед:

Дт Өмчийн хөрөнгө оруулалт
Кт Хөрөнгө оруулалтын орлого

(б) тайлант үеийн эцэст санхүүжигч байгууллага алдагдалтай ажилласан бол уг цэвэр алдагдлаас ногдох хувь оролцоогоор тооцоолж хөрөнгө оруулалтаа бууруулна. Санхүүжигч байгууллагын алдагдлаас эзэмшлийн хувь оролцоогоор хүлээн зөвшөөрөх үед:

Дт Хөрөнгө оруулалтын зардал
Кт Өмчийн хөрөнгө оруулалт

(в) санхүүжигчээс хүлээн авсан ногдол ашиг болон түүнтэй адилтгах хуваарилалтаар тухайн хөрөнгө оруулалтын дансны үнийг бууруулах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Ногдол ашгийн авлага
Кт Өмчийн хөрөнгө оруулалт

Өртгийн арга

7.8.Хөрөнгө оруулалтыг өртгийн аргаар бүртгэх үед:

(а) хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх үед:

Дт Бусад гарз – Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз
Кт Өмчийн хөрөнгө оруулалт

(б) ногдол ашгийг хүлээн зөвшөөрөх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Ногдол ашгийн авлага
Кт Ногдол ашгийн орлого

Бодит үнэ цэнийн арга

7.9.Бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө оруулалтыг санхүүгийн хөрөнгийн ангиллаас хамааран ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих, эсхүл цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих гэсэн хоёр ангиллын аль нэгээр бүртгэнэ.

7.10.Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) тайлант үеийн эцэст хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ өссөн үед:

Дт Өмчийн хөрөнгө оруулалт
Кт Бодит үнэ цэнийн үнэлгээний олз

(б) тайлант үеийн эцэст хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ буурсан бол:

Дт Бодит үнэ цэнийн үнэлгээний гарз
Кт Өмчийн хөрөнгө оруулалт

(в) ногдол ашгийг хүлээн зөвшөөрөх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Ногдол ашгийн авлага
Кт Ногдол ашгийн орлого

7.11.Зөвхөн борлуулахад бэлэн ангиллын санхүүгийн хөрөнгийн хувьд цэвэр хөрөнгө/өмчөөр дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба дараах байдлаар бүртгэнэ:

(а) тайлант үеийн эцэст хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ өссөн үед:

Дт Өмчийн хөрөнгө оруулалт
Кт Бусад цэвэр хөрөнгө/өмч

(б) тайлант үеийн эцэст хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ буурсан бол:

Дт Бусад цэвэр хөрөнгө
Кт Өмчийн хөрөнгө оруулалт

(в) ногдол ашгийг хүлээн зөвшөөрөх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Ногдол ашгийн авлага
Кт Ногдол ашгийн орлого

Үл хүлээн зөвшөөрөлт

7.12.Өмчийн хөрөнгө оруулалтыг борлуулсан бол тухайн өдрийн дансны үнэ ба хүлээн авсан хөрөнгийн зөрүүгээр олз, гарз хүлээн зөвшөөрнө.

(а) хөрөнгө оруулалтыг олзтой борлуулах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Өмчийн хөрөнгө оруулалт
Кт Хөрөнгө оруулалт борлуулсны олз

(б) хөрөнгө оруулалтыг гарзтай борлуулах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Дт Хөрөнгө оруулалт борлуулсны гарз
Кт Өмчийн хөрөнгө оруулалт

НАЙМДУГААР БҮЛЭГ БАРАА МАТЕРИАЛ

8.1.Үйлдвэрлэлд ашиглах түүхий эд материал, үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа, худалдан борлуулах, хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа, борлуулах буюу хуваарилахын тулд үйлдвэрлэлийн дамжлагад байгаа хөрөнгө бараа материалд хамрагдана.

8.2.Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.

8.3.Бараа материалыг УСНББОУС 12 *Бараа материал*-ын дагуу бүртгэнэ.

8.4.Бараа материалыг дараах тохиолдолд зардлаар хүлээн зөвшөөрнө:

(а) бараа материалыг борлуулах, солилцох, хуваарилах тохиолдолд холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед түүний дансны үнийг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Хэрэв хамаарах орлого байхгүй бол барааг хуваарилсан буюу үйлчилгээг үзүүлсэн үед зардлыг хүлээн зөвшөөрнө.

(б) бараа материалын бууруулалтын дүн ба бараа материалын бүх гарзыг гарсан тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө. Бараа материалын бууруулалтын буцаалтыг өмнө нь зардлаар хүлээн зөвшөөрсөн дүнгийн бууралт байдлаар хүлээн зөвшөөрнө.

8.5.Байгууллага нь хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсний үр дүнд бий болсон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (ноос, ноолуур, мах, жимс, ногоо гэх мэт)-ийг бараа материал гэж бүртгэнэ.

8.6.Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд энэ журмын 2.6-д заасны дагуу хэмжинэ.

8.7.Бараа материалыг хариу төлбөргүй хуваарилах зорилгоор эзэмшиж буй тохиолдолд өртөг ба одоогийн орлуулалтын өртгийн аль багаар нь хэмжинэ.

8.8.Бараа материалыг худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй тохиолдолд өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжинэ.

8.9.Хэрэв бараа материалын одоогийн орлуулалтын өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй үед өртгөөр нь хэмжинэ.

8.10.Одоогийн орлуулалтын өртөг гэж тайлангийн өдрөөр тухайн хөрөнгийг олж эзэмшихийн тулд байгууллагын зарцуулах байсан өртгийг хэлнэ.

8.11.Цэвэр боломжит үнэ цэнэ гэж хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгох ба борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилахад шаардлагатай тооцоолсон өртөг, зардлыг хассан дүнг хэлнэ.

8.12.Бараа материалын өртөгт худалдан авалтын бүх өртөг зардал, хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гарсан бүх зардал орно.

8.13.Бараа материалын худалдан авалтын өртөг нь (а) худалдан авсан үнэ, (б) импортын татвар ба бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас тухайн байгууллага дараа нь нөхөн авч болохоос бусад), (в) тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээний худалдан авалтад шууд хамаарах бусад зардлуудаас бүрддэг. Худалдан авалтын өртгийг тодорхойлохдоо худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлсийг хасна.

8.14.Хувиргалтын зардал нь үйлдвэрлэлийн орчинд гарах бөгөөд түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэлийн өртгийг бэлэн бүтээгдэхүүн болгон хувиргах зардлыг хэлнэ. Хувиргалтын зардалд шууд хөдөлмөрийн зардал, тогтмол болон хувьсах үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлууд багтана.

8.15.Бусад зардал гэж бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гарсан бусад зардлыг тухайн бараа материалын өртөгт оруулан тооцно. Бараа материалын өртөгт оруулдаггүй бөгөөд зардлын жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) хаягдал материал, хөдөлмөр буюу үйлдвэрлэлийн бусад зардлын хэвийн бус дүн;
- (б) үйлдвэрлэлийн дараагийн шат дамжлагад оруулахын өмнө тухайн үйлдвэрлэлд зайлшгүй гарах шаардлагатайгаас бусад хадгалалтын зардал;
- (в) бараа материалыг одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гараагүй удирдлагын нэмэгдэл зардал; ба
- (г) борлуулалтын зардал.

Биологийн хөрөнгөөс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртөг

8.16.Төсвийн байгууллага нь хөдөө аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болох бараа материалыг УСНББОУС 27 Хөдөө аж ахуй-н дагуу анх хүлээн зөвшөөрөхдөө үр шим авалтын цэг дээрх түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Бараа материалын өртгийг тооцох аргууд

8.17.Төсвийн байгууллага нь худалдан борлуулсан, үйлдвэрлэл үйлчилгээнд зарцуулсан бараа материалын өртгийг тооцохдоо эхэлж авсныг эхэлж зарлагдах арга, жинлэсэн дундаж өртгийн арга, тусгай тэмдэглэгээний аргаас аль тохиромжтойг сонгож, тогтвортой мөрдөнө.

8.18.Эхэлж авсныг эхэлж зарлагдах аргын үед эхлээд худалдан авсан бараа материалыг эхэлж борлуулна гэж төсөөлдөг бөгөөд иймээс тайлант үеийн эцэст үлдэж байгаа бараа материал нь хамгийн сүүлд худалдан авсан буюу үйлдвэрлэсэн зүйлс байна.

8.19.Жинлэсэн дундаж өртгийн аргын үед тайлант үеийн эхэнд байсан ижил төрлийн бараа материал ба тухайн тайлант үеийн туршид худалдаж авсан буюу үйлдвэрлэсэн ижил төрлийн бараа материалын жинлэсэн дундаж өртгөөр тухайн бараа материал зүйл тус бүрийн өртгийг тодорхойлно. Тухайн байгууллагын нөхцөл байдлаас хамааран жинлэсэн дундаж өртгийг үечилсэн байдлаар, эсхүл нэмэлт татан авалтыг хүлээн авах бүрд тооцоолж болно.

8.20.Тусгай тэмдэглэгээний аргын үед харилцан сольж орлуулах боломжгүй бараа материал, түүнчлэн тусгай төслүүдэд зориулан үйлдвэрлэсэн ба тусгаарласан бараа, эсхүл үйлчилгээний өртгийг тодорхойлно.

8.21.Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ.

Бараа материал олж бэлтгэх, хүлээн авах

(а) бараа материалыг худалдан авсан үед өртгөөр нь:

Дт Бараа материал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Дансны өглөг/ Урьдчилж төлсөн тооцоо

(б) бараа материалыг тусламжаар хүлээн авсан үед:

Дт Бараа материал /нэр төрлөөр/
Кт Хөрөнгийн тусламжийн орлого

(в) бараа материалыг бусад төсвийн байгууллагад шилжүүлэх үед:

Дт Төсвийн байгууллага хоорондын хөрөнгийн шилжүүлэг
Кт Бараа материал /нэр төрлөөр/

(г) бусад төсвийн байгууллагаас бараа материал хүлээн авсан үед:

Дт Бараа материал /нэр төрлөөр/
Кт Төсвийн байгууллага хоорондын гүйлгээгээр хүлээн авсан хөрөнгийн орлого

(д) бараа материалыг ажил, үйлчилгээнд зарцуулах үед:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Бараа материал /нэр төрлөөр/

(е) бараа материалыг борлуулах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Авлага
Кт Төсвийн байгууллагын өөрийн орлого

Дт Бараа материалын зардал
Кт Бараа материал /нэр төрлөөр/

(ё) үндсэн хөрөнгийг данснаас хасаж, бараа материалын дансанд орлого авах үед:

- Дт Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз
- Дт Хуримтлагдсан элэгдэл
- Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
- Дт Бараа материал /нэр төрлөөр/
- Кт Бусад орлого /нэр төрлөөр/

Дотооддоо үйлдвэрлэн, зарцуулж буй бараа материал

(ж) үйлдвэрлэлд гарсан зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримтлуулах болон бусад зардлаас хуваарилах үед:

- Дт Дуусаагүй үйлдвэрлэл
- Кт Бараа материал/ холбогдох бусад данс

(з) тооцоолсон өртгөөр бараа материалыг орлогод авах үед:

- Дт Бараа материал /нэр төрлөөр/
- Кт Дуусаагүй үйлдвэрлэл

(и) зарцуулах үед:

- Дт Бараа материалын зардал
- Кт Бараа материал /нэр төрлөөр/

Нормын хувцас, хэрэгсэл

8.19.Байгууллага нормын хувцас, хэрэгслийг зардалд хүлээн зөвшөөрөхдөө ашиглалтад тавьж олгох үед, эсхүл ашиглалтаас хасах үед гэсэн хоёр хувилбарын аль тохиромжтойгоор бүртгэнэ.

(а) нормын хувцас, хэрэгслийг ашиглалтад тавьж олгосон үед тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрөх тохиолдолд:

- Дт Зардал /нэр төрлөөр/
- Кт Хангамжийн материал /нэр төрлөөр/

(б) ашиглалтад тавьж олгосон нормын хувцас, хэрэгслийг хэрэглэж байгаа ажилтны нэр дээр карт хөтлөх ба ашиглалтаас хасах үед зардлаар хүлээн зөвшөөрөх тохиолдолд:

- Дт Зардал /нэр төрлөөр/
- Кт Хангамжийн материал /нэр төрлөөр/

(в) нормын хувцас, хэрэгслийг ашиглалтын хугацаанаас өмнө данснаас хасаж ажилтнаар төлүүлэх тохиолдолд:

- Дт Зардал /нэр төрлөөр/
- Кт Хангамжийн материал /нэр төрлөөр/
- Дт Ажилтнаас авах авлага
- Кт Бусад орлого /нэр төрлөөр/

Бараа материалын тооллого

(г) тооллогоор бараа, материалын дутагдал гарч, дутагдлыг эд хариуцагчаар төлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд:

- Дт Бараа материалын зардал
- Кт Бараа материал /нэр төрлөөр/
- Дт Ажилтнаас авах авлага
- Кт Бусад орлого /нэр төрлөөр/

(д) тооллогоор илэрсэн бараа материалын дутагдал нь эд хариуцагчийн буруугаас биш бол:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Бараа материал /нэр төрлөөр/

(е) тооллогоор бараа материал илүүдсэн бол орлогоор бүртгэнэ:

Дт Бараа материал /нэр төрлөөр/
Кт Бусад орлого /нэр төрлөөр/

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжих

8.20.Бараа материалыг өртөг ба одоогийн орлуулалтын өртгийн аль багаар, эсхүл өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжихдээ бараа материалын нийт дүнгийн аргыг ашиглана.

(а) бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ түүний өртгөөс бага бол өртгийг бууруулж үнэ цэнийн бууралтыг дараах байдлаар бүртгэнэ.

Дт Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз
Кт Бараа материал /нэр төрлөөр/

(б) бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ өртгөөс их болсон тохиолдолд буцаах бичилтийг хийнэ.

Дт Бараа материал /нэр төрлөөр/
Кт Үнэ цэнийн бууралтын буцаалт

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн

(в) хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгээр хүлээн зөвшөөрөх үед:

Дт Бараа материал /нэр төрлөөр/
Кт Бодит үнэ цэнийн үнэлгээний олз

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ УРЬДЧИЛГАА

9.1.Урьдчилгаа нь урьдчилж төлсөн зардал болон урьдчилж төлсөн тооцооноос бүрдэнэ. Энэ нь тайлангийн үед мөнгөөр гарсан боловч дараагийн тайлант үеийн зардал буюу бараа, үйлчилгээгээр тооцогдох ирээдүй цагийн зарлагыг илэрхийлнэ.

9.2.Урьдчилж төлсөн тооцоо гэж худалдан авах бараа, үйлчилгээний үнийг урьдчилан төлснийг хэлнэ.

9.3.Урьдчилж төлсөн зардал гэж нэг буюу хэд хэдэн тайлант үед ногдох зардлыг урьдчилан төлсөнтэй холбоотой үүснэ. Жишээ нь, урьдчилж төлсөн даатгалын зардал, урьдчилж төлсөн үйл ажиллагааны түрээс гэх мэт.

9.4.Урьдчилгааг төлсөн мөнгөн дүнгээр хэмжинэ.

9.5.Урьдчилж төлсөн зардлыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) зардлыг урьдчилж төлөх үед:

Дт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(б) урьдчилж төлсөн зардлыг хэрэгжсэн үед холбогдох тайлант үеийн зардлаар бүртгэнэ:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Урьдчилж төлсөн зардал /нэр төрлөөр/

9.6. Урьдчилж төлсөн тооцоог дараах байдлаар бүртгэнэ:

(а) урьдчилгаа төлбөр болон томилолтын зардлыг шилжүүлэх үед:

Дт Урьдчилж төлсөн тооцоо /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(б) урьдчилж төлсөн тооцоог хаах үед:

Дт Авлага /нэр төрлөөр/
Дт Зардал /нэр төрлөөр/
Дт Бараа материал /нэр төрлөөр/
Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Урьдчилж төлсөн тооцоо /нэр төрлөөр/

(в) хөрөнгийг худалдан авч, олж бэлтгэхээр урьдчилгаа тооцоо үүсгэсэн үед бэлтгэн нийлүүлэгч тал үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд урьдчилж төлсөн тооцоог авлага болгон ангиллыг өөрчилнө:

Дт Авлага /нэр төрлөөр/
Кт Урьдчилж төлсөн тооцоо /нэр төрлөөр/

АРАВДУГААР БҮЛЭГ ҮНДСЭН ХӨРӨНГӨ

10.1. Үндсэн хөрөнгө нь бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдах биет хөрөнгө юм.

10.2. Дэд бүтцийн хөрөнгөнд систем буюу сүлжээний нэг хэсэг бөгөөд тусгайлсан шинж төрөлтэй ба өөр хувилбараар ашиглах боломжгүй, хөдлөх шинжтэй, данснаас хасахад хязгаарлалттай хөрөнгүүд хамаарна. Үүнд зам, гүүр, бохир зайлуулах систем, усны болон цахилгаан хангамжийн систем, харилцаа холбооны сүлжээ бусад байгууламж хамаарна.

10.3. Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмжид энхийн цагт сүр хүчийг үзүүлэх зорилгоор эзэмшдэг, батлан хамгаалах үйлчилгээнд байнга ашиглагдах цэргийн нисэх онгоц, танк, пуужин тээвэрлэгч, хөөргөх систем зэрэг тээвэрлэгч хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмж хамаарна.

10.4. Зарим хөрөнгийг соёл, байгаль орчин, түүхийн ач холбогдлыг харгалзан соёлын өв хөрөнгө гэж тодорхойлно. Үүнд түүхэн байшин барилга, хөшөө дурсгал, урлагийн бүтээл зэрэг хөрөнгө хамаарна.


10.5. Үндсэн хөрөнгийн бүртгэлд УСНББОУС 17 *Үндсэн хөрөнгө*, УСНББОУС 21 *Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, УСНББОУС 26 *Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, УСНББОУС 5 *Зээлийн өртөг* -ийг мөрдөнө.

10.6. Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд байгууллагын хэрэгцээнд ашиглах, бусдад түрээслүүлэх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

10.7.Санхүүгийн түрээсийн гэрээгээр хөрөнгө түрээсэлж байгаа нөхцөлд түрээсийн өдрөөр холбогдох үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

10.8.Сэлбэг, нөөцөд байгаа тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хийгдэж буй тоног төхөөрөмж гэх мэт үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа зүйлс нь үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангасан тохиолдолд үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Харин тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд эдгээр зүйлсийг бараа материал гэж ангилна.

10.9.Үндсэн хөрөнгө, бараа материалын хүлээн зөвшөөрөлтөд доорх шийдвэрийн модыг ашиглаж болно.



10.10.Үндсэн хөрөнгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх босго үнийг зөвхөн тавилга эд, хогшлын ангид байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тогтоож болно.

10.11.Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжих ба өртөг нь хөнгөлөлт, буцаалтыг хассан худалдан авалтын үнэ, түүнийг бэлтгэхтэй холбоотой гарсан тээврийн зардал, гаалийн татвар, хураамж, угсарч суурилуулах, ачиж буулгах гэх мэт шууд хамаарах зардлуудаас бүрдэнэ.

10.12.Байгууллага өөрөө барьж байгуулж байгаа үндсэн хөрөнгийн өртөгт барилгыг барьж, ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэл гарсан бүх зардал багтана.

10.13.Олон төрлийн хөрөнгийг багцаар худалдан авах буюу хэд хэдэн хөрөнгийг нэг нийлбэр дүнгээр худалдан авч байгаа тохиолдолд харгалзах бодит үнэ цэнээр нь өртгийг хуваарилж, хэмжинэ.

10.14.Үндсэн хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд бодит үнэ цэнээр хэмжинэ.

10.15.Байгууллага нь материаллаг дүн бүхий томоохон үндсэн хөрөнгө, барилга, дэд бүтцийн хөрөнгийн бүрэлдэхүүнд багтдаг зүйлийг орлуулж, сольж байгаа тохиолдолд хасаж байгаа зүйлийн өртгийг зардлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь орлуулагдан хасагдаж буй зүйлийн дансны үнийг тодорхойлох практик боломжгүй байвал уг орлуулан нэмэгдэж буй өртгийг ашиглаж болно.

10.16.Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа өртгийн ба дахин үнэлгээний загварын аль нэгээр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна.

(а) өртгийн загвар нь хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа түүний анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ.

(б) дахин үнэлгээний загвар нь дахин үнэлгээний өдрөөрх хөрөнгийн бодит үнэ цэнээс дараагийн тайлант үеийн аливаа хуримтлагдсан элэгдэл ба дараагийн тайлант үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ.

10.17.Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийг дахин үнэлгээний загвараар бүртгэнэ.

10.18.Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийхдээ тухайн хөрөнгийн харьяалагдаж буй үндсэн хөрөнгийн ангийг нийтэд нь дахин үнэлнэ.

10.19.Дахин үнэлгээ хийх давтамж нь дахин үнэлж буй тухайн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн материаллаг өөрчлөлтөөс хамаарна.

10.20.Төсвийн байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу Засгийн газраас гаргасан эд хөрөнгийг дахин үнэлэх тухай шийдвэрийг, эсхүл Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан эрх бүхий этгээдийн шийдвэрийг тус тус үндэслэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ.

Элэгдэл

10.21.Элэгдэл нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацаанд хуваарилах системтэй хуваарилалт юм.

10.22.Үндсэн хөрөнгийн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ.

10.23.Элэгдүүлэх дүн нь хөрөнгийн өртөг, эсхүл өртгийг орлох бусад дүнгээс үлдэх өртгийг хассан дүн юм. Үлдэх өртөг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст түүнийг данснаас хасахтай холбоотой аливаа зардлыг хассаны дараа байгууллагад орж ирэх дүнг хэлнэ.

10.24.Хөрөнгийн ашиглалтын хугацаа нь байгууллага тухайн хөрөнгийг ашиглахаар хүлээгдэж буй хугацаа, эсхүл тухайн хөрөнгийг ашиглан үйлдвэрлэхээр хүлээгдэж буй бүтээгдэхүүний хэмжээ, түүнтэй адилтгах нэгж юм.

10.25.Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ.


10.26.Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн үед элэгдлийг зогсооно. Иймээс хөрөнгийг бүрэн элэгдүүлээгүй л бол түүнийг ашиглаагүй сул зогссон, эсхүл идэвхтэй ашиглалтаас хассан ба данснаас хасах зорилгоор эзэмшиж байгаа тохиолдолд элэгдлийг зогсоохгүй.

10.27.Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ.

Үнэ цэнийн бууралт

10.28.Байгууллага нь хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21 *Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, УСНББОУС 26 *Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт* -ын дагуу хэмжиж, хүлээн зөвшөөрнө.

10.29.Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлтийг доорх шийдвэрийн модоор харуулав.



10.30. Байгууллага нь хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үеийн эцэст үнэлнэ. Хэрэв ямар нэгэн шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолж, үнэ цэнийн бууралтыг бүртгэнэ.

10.31. Үнэ цэнийн бууралтыг мөнгөн бий болгогч хөрөнгө болон мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хувьд адилхан тодорхойлдог боловч хөрөнгийн үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг үнэлэх, үнэ цэнийн бууралтын дүнг хэмжих, хүлээн зөвшөөрөхөд тавигдах шаардлага нь ялгаатай байдаг.

10.32. Мөнгө бий болгогч хөрөнгө гэж ашиг олох үндсэн зорилготойгоор эзэмшиж буй хөрөнгийг хэлнэ. Мөнгө бий болгогч хөрөнгөөс бусад хөрөнгийг мөнгө бий болгодоггүй хөрөнгө гэж үзнэ.

10.33. Мөнгө бий болгогч хөрөнгийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс бага байгаа тохиолдолд хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл нь бууруулж, үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрнө.

10.34. Хөрөнгийн нөхөгдөх дүнг хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулалттай холбоотой зардлыг хассан дүн ба ашиглалтын үнэ цэнийн аль ихээр тогтооно. Хөрөнгийн бодит үнэ цэнэ гэж түүнийг худалдах, солилцох, эсхүл өр төлбөрөөр тооцож болох дүн юм. Ашиглалтын үнэ цэнэ гэж тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ юм.

10.35. Хэрэв хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь тодорхойлох боломжгүй бол хэдэн хэдэн хөрөнгийн хамт бүлэглэн мөнгө бий болгогч нэгж үүсгэн, үнэ цэнийн бууралтыг тооцоолно. Мөнгө бий болгогч нэгж гэж бусад хөрөнгө болон хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгодог хөрөнгүүдийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм. Мөнгө бий болгогч нэгжийг ашиглан үнэлгээ хийсэн бол үнэ цэнийн бууралтын гарзыг эхлээд гүүдвилд хуваарилах ба үлдсэн хэсгийг нь бусад хөрөнгүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна.

10.36.Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүн нь түүний дансны үнээс бага байгаа тохиолдолд хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл нь бууруулж, үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрнө.

10.37.Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр нөхөгдөх үйлчилгээний дүнг тодорхойлно.

10.38.Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийн тооцоололд ашиглах мөнгөн гүйлгээг тодорхойлох боломжгүй тохиолдолд мэдээллийн олдоц, үнэ цэнийн бууралтын шинж төрлийг харгалзан үзэж, элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага, нөхөн сэргээлтийн өртгийн хандлага, үйлчилгээний нэгжийн хандлага зэрэг аргуудаас сонгон хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхыг тооцоолно.

10.39.Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг хэрхэн тодорхойлохыг дараах жишээнүүдээр тайлбарлав.

(а) элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага: Төсвийн байгууллага 8 сая төгрөгөөр төхөөрөмж худалдан авсан бөгөөд ашиглалтын хугацааг 5 жил гэж тооцоолсон. Хөрөнгийг 3 жил ашигласны дараа технологийн өөрчлөлтийн улмаас уг төхөөрөмжийн үнэ цэнэ буурсан. Уг төхөөрөмжийн үйлчилгээний чадавхыг бүрдүүлэх хүчин чадалтай төхөөрөмжийг 600,000 төгрөгөөр худалдан авах боломжтой.

Худалдан авалтын өртөг	8,000,000	Орлуулалтын өртөг	600,000
<u>Хуримтлагдсан элэгдэл</u>	<u>(4,800,000)</u>	<u>Хуримтлагдсан элэгдэл</u>	<u>(360,000)</u>
Дансны үнэ	3,200,000	Нөхөгдөх үйлчилгээний дүн	240,000

Үнэ цэнийн бууралтын гарз = 3,200,000 – 240,000 = 2,960,000 төгрөг

(б) нөхөн сэргээлтийн өртгийн хандлага: Төсвийн байгууллага 9 сая төгрөгөөр автомашин худалдан авсан бөгөөд ашиглалтын хугацаа 10 жил гэж тооцоолсон. Уг автомашиныг 6 жил ашигласны дараа осолд орж эвдэрсэн ба хэвийн байдалд оруулахын тулд засвар үйлчилгээнд 1 сая төгрөг зарцуулах шаардлагатай болсон. Ижил үйлчилгээ үзүүлэх автомашиныг 10 сая төгрөгөөр худалдан авах боломжтой.

Худалдан авалтын өртөг	9,000,000	Орлуулалтын өртөг	10,000,000
<u>Хуримтлагдсан элэгдэл</u>	<u>(5,400,000)</u>	<u>Хуримтлагдсан элэгдэл</u>	<u>(6,000,000)</u>
Дансны үнэ	3,600,000	Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг	4,000,000
		<u>Нөхөн сэргээлтийн өртөг</u>	<u>(1,000,000)</u>
		Нөхөгдөх үйлчилгээний дүн	3,000,000

Үнэ цэнийн бууралтын гарз = 3,600,000 – 3,000,000 = 600,000 төгрөг

(в) үйлчилгээний нэгжийн хандлага: Төсвийн байгууллага 5 сая төгрөгөөр төхөөрөмж худалдан авсан бөгөөд 10 жил ашиглана гэж тооцоолсон. Уг төхөөрөмжийг 5 жил ашигласны дараа гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр хүчин чадал нь 20%-иар буурсан. Ижил зориулалт бүхий төхөөрөмжийн орлуулалтын өртөг 6 сая төгрөг.

Худалдан авалтын өртөг	5,000,000	Орлуулалтын өртөг	6,000,000
<u>Хуримтлагдсан элэгдэл</u>	<u>(2,500,000)</u>	<u>Хуримтлагдсан элэгдэл</u>	<u>(3,000,000)</u>
Дансны үнэ	2,500,000	Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг	3,000,000
		Нөхөгдөх үйлчилгээний дүн	2,400,000

Үнэ цэнийн бууралтын гарз = 2,500,000 – 2,400,000 = 100,000 төгрөг

10.40.Үндсэн хөрөнгийн дансны үнийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:

10.40.1.Хөрөнгийг данснаас хассан;

10.40.2.Хөрөнгийн ашиглалт, эсхүл данснаас хасалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавх хүлээгдэхээргүй болсон.

10.41.Элэгдэл ба үнэ цэнийн бууралтаараа өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг ашиглалтаас хасах хүртэл тухайн хөрөнгийг бүртгэлд хэвээр тусгана.

10.42.Үндсэн хөрөнгийг олж бэлтгэх, шилжүүлэх ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

(а) үндсэн хөрөнгө худалдан авах үед өртгөөр нь хэмжиж, бүртгэнэ:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг

(б) үндсэн хөрөнгө тусламжаар хүлээн авах үед:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Хөрөнгийн тусламжийн орлого, эсхүл хойшлогдсон орлого

Хөрөнгийн тусламжийг хойшлогдсон орлогыг хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид системтэйгээр орлогоор хүлээн зөвшөөрнө.

Дт Хойшлогдсон орлого
Кт Орлого

(в) санхүүгийн түрээсээр үндсэн хөрөнгө авсан тохиолдолд түрээсэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар түрээсийн хөрөнгийг хэмжинэ. Түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах үр ашигт хүү нь түрээслэгчийн ашиглаж буй нуугдмал хүү байна.

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Түрээсийн өглөг

Үндсэн хөрөнгийн шилжүүлэг

(г) бусад төсвийн байгууллагад шилжүүлэх зорилгоор үндсэн хөрөнгө, бараа материал худалдан авах үед:

Дт Бусад санхүүгийн бус хөрөнгө, эсхүл Бараа материал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг

Тухайн хөрөнгийг шилжүүлэх үед:

Дт Төсвийн байгууллага хоорондын хөрөнгийн шилжүүлэг
Кт Бусад санхүүгийн бус хөрөнгө/ Бараа материал /нэр төрлөөр/

(д) бусад төсвийн байгууллагаас шинэ үндсэн хөрөнгө хүлээн авах үед:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Төсвийн байгууллага хоорондын гүйлгээгээр хүлээн авсан хөрөнгийн орлого

(е) бусад төсвийн байгууллагад хуучин үндсэн хөрөнгө шилжүүлэх үед:

Дт Төсвийн байгууллага хоорондын хөрөнгийн шилжүүлэг

Дт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

(ё) бусад төсвийн байгууллагаас хуучин үндсэн хөрөнгө хүлээн авахад тухайн өдрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлж чадахгүй тохиолдолд үлдэгдэл өртгөөр хэмжинэ.

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Төсвийн байгууллага хоорондын гүйлгээгээр хүлээн авсан хөрөнгийн орлого

(ж) илүүдэл эд хөрөнгө болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоосон тохиолдолд хөрөнгийг данснаас хасаж, уг тогтоосон үнээр шинэ хөрөнгө хүлээн зөвшөөрнө. Мөн уг хөрөнгийн цаашид ашиглагдах хугацааг шинэчлэн тогтоож, элэгдэл байгуулна.

Дт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Дт Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Бусад орлого /нэр төрлөөр/

(з) үндсэн хөрөнгийг өөрөө барьж байгуулж байгаа тохиолдолд холбогдох өртгийг дуусаагүй барилга дансанд хуримтлуулна:

Дт Дуусаагүй барилга
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг

(и) барилгын ажил дуусаж, мэргэжлийн байгууллагаас ашиглах зөвшөөрөл авсан бол дуусаагүй барилгаа үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлж бүртгэнэ:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Дуусаагүй барилга

Үндсэн хөрөнгийн солилцоо

10.43.Солилцооны ажил гүйлгээ нь арилжааны бус шинж чанартай бол авсан хөрөнгийг өгсөн хөрөнгийн дансны үнээр хэмжиж, бүртгэнэ:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Дт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

10.44.Хэрэв хөрөнгийн солилцоо арилжааны шинж чанартай бол авсан хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд уг хөрөнгийг тухайн өдрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Харин авсан хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд уг хөрөнгийг өгсөн хөрөнгийн дансны үнээр хэмжинэ.

(а) арилжааны ажил гүйлгээгээр хүлээн авсан хөрөнгийн бодит үнэ цэнэ нь өгсөн хөрөнгийн дансны үнээс их бол олз үүснэ:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Дт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Үндсэн хөрөнгө солилцооны олз/ Бусад олз
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

(б) арилжааны ажил гүйлгээгээр хүлээн авсан хөрөнгийн бодит үнэ цэнэ нь өгсөн хөрөнгийн дансны үнээс бага бол гарз үүснэ:

Дт	Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Дт	Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Дт	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз
Кт	Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

Дараа үеийн зардал

10.45.Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа үед гарсан зардал нь хөрөнгийн ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлээгүй, хэвээр хадгалан, нөхөн сэргээж байвал уг зардлыг тайлант үеийн зардал болгон бүртгэнэ.

Дт	Засварын зардал
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг/ Бараа материал/ Холбогдох бусад данс

10.46.Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа үед гарсан зардал нь хөрөнгийн ерөнхий чанарыг сайжруулж, анх тогтоосон бүтээмжийг дээшлүүлж, байгууллагын ирээдүйд хүртэх өгөөжийг нэмэгдүүлж байвал ийм зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулж бүртгэнэ.

Дт	Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг/ Бараа материал/ Холбогдох бусад данс

Элэгдэл

10.47.Байгууллага нь элэгдэл тооцох тохиромжтой аргыг ашиглан хөрөнгийг элэгдүүлнэ.

Дт	Элэгдлийн зардал
Кт	Хуримтлагдсан элэгдэл

Үнэ цэнийн бууралт

10.48.Үнэ цэнийн бууралт нь хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхын бууралтыг элэгдлээр дамжуулан системтэй хүлээн зөвшөөрөх дүнгээс илүү буюу өндрөөр тухайн хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхад учрах гарз юм.

(а) дахин үнэлгээ хийгээгүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг бүртгэх үед:

Дт	Үнэ цэнийн бууралтын гарз
Кт	Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

(б) дахин үнэлгээ хийсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг дахин үнэлгээний бууралт гэж бүртгэнэ.

Дт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
Кт	Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

(в) дахин үнэлгээний бууралт нь дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлээс хэтэрсэн тохиолдолд зөрүүгээр гарз хүлээн зөвшөөрнө:

Дт	Үнэ цэнийн бууралтын гарз
Дт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл
Кт	Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт

10.49.Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байхаа больсон буюу буурсан байж болох шинж тэмдэг байгаа бол үнэ цэнийн бууралтыг буцаах ба буцаалт нь хуримтлагдсан үнэ цэнийн бууралтаас хэтрэхгүй.

(а) хөрөнгийн үнэ цэнийн бууралт гарзын буцаалтын дүнгээр олз хүлээн зөвшөөрнө:

Дт Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Үнэ цэнийн бууралтын буцаалт

(б) мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг тухайн нэгж дэх гүүдвилээс бусад хөрөнгүүдэд тэдгээр хөрөнгийн дансны үнээр хувь тэнцүүлэн хуваарилна.

Дт Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт /нэр төрлөөр/
Дт Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт /нэр төрлөөр/
Кт Үнэ цэнийн бууралтын буцаалт

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ

10.50.Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн тохиолдолд уг нэмэгдлийн хэмжээгээр цэвэр хөрөнгө/өмчийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэнэ.

(а) үндсэн хөрөнгийг анх удаа дахин үнэлэх үед түүний өртгийг нэмэгдүүлсэн бол:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Дахин үнэлгээний нэмэгдэл

(б) өмнө нь дахин үнэлгээний зардал бүртгэсэн хөрөнгийн хувьд дараагийн дахин үнэлгээгээр дансны үнэ нэмэгдвэл олзоор хүлээн зөвшөөрнө.

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Бодит үнэ цэнийн үнэлгээний олз

10.51.Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан тохиолдолд зардлаар хүлээн зөвшөөрнө.

(а) үндсэн хөрөнгийг анх удаа дахин үнэлэх үед түүний өртгийг бууруулсан бол:

Дт Бодит үнэ цэнийн үнэлгээний гарз
Дт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

(б) өмнө нь дахин үнэлгээний нэмэгдэл бүртгэсэн хөрөнгийн хувьд дараагийн дахин үнэлгээгээр дансны үнэ буурвал холбогдох дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна.

Дт Дахин үнэлгээний нэмэгдэл
Дт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

Үндсэн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

10.52. Үндсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бүртгэсний үр дүнд түүний өртгийг үндсэн хөрөнгийн данснаас хасах ба хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралт, түүнд хамаарах дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдлийг хаана.

(а) хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг данснаас хасах үед:

Дт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

(б) хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөөгүй үндсэн хөрөнгийг данснаас хасах үед дансны үнийн дүнгээр гарз хүлээн зөвшөөрнө:

Дт Хуримтлагдсан элэгдэл/ Хуримтлагдсан үнэ цэнийн бууралт
Дт Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

(в) үндсэн хөрөнгийг үлдэгдэл өртгөөс нь илүү үнээр борлуулсан бол борлуулсан үнэ ба дансны үнийн зөрүүгээр олз хүлээн зөвшөөрнө:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Авлага
Дт Хуримтлагдсан элэгдэл
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Үндсэн хөрөнгө борлуулсны олз

(г) үндсэн хөрөнгийг үлдэгдэл өртгөөс нь бага үнээр борлуулсан бол дансны үнэ ба борлуулсан үнийн зөрүүгээр гарз хүлээн зөвшөөрнө:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Авлага
Дт Хуримтлагдсан элэгдэл
Дт Үндсэн хөрөнгө борлуулсны гарз
Кт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/

(д) үндсэн хөрөнгийг данснаас хасах үед харгалзах дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан үр дүн дансанд хаана:

Дт Дахин үнэлгээний нэмэгдэл
Кт Хуримтлагдсан үр дүн

Төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө бэлтгэх

10.53. Төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө бэлтгэх үед захиалагч байгууллага болох төсвийн ерөнхийлөн /төвлөрүүлэн/ захирагч нь барилга байгууламж болон их засварын хувьд ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр шилжүүлэх зориулалттай бусад санхүүгийн бус хөрөнгөөр тус тус бүртгэнэ.

(а) хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хүлээн авах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Төсвийн санхүүжилтийн орлого /нэр төрлөөр/

(б) хүлээн авсан гүйцэтгэлийн дүнгээр гүйцэтгэгч байгууллагад төлбөрийг шилжүүлэх үед:

Дт Бусад санхүүгийн бус хөрөнгө
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(в) хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бэлтгэсэн хөрөнгийг эзэмшигч байгууллагад шилжүүлэх үед:

Дт Төсвийн байгууллага хоорондын хөрөнгийн шилжүүлэг
Кт Бусад санхүүгийн бус хөрөнгө

(г) хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бэлтгэгдсэн хөрөнгийг хүлээн авсан байгууллага нь:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Төсвийн байгууллага хоорондын гүйлгээгээр хүлээн авсан хөрөнгийн орлого

Барьцаа

10.56.Гүйцэтгэгч байгууллагаас бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг барьцаа хөрөнгө болгон захиалагч байгууллагын дансанд байршуулна.

(а) захиалагчийн дансанд гүйцэтгэгчээс барьцаа хөрөнгө орох үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Байгууллагад төлөх өглөг

(б) гүйцэтгэгч нь ажлыг бүхэлд нь дуусгаж банкны батлан даалтыг захиалагчид гарган өгнө. Уг батлан даалтын дүнтэй тэнцүү хэмжээний төлбөрийг барьцаа хөрөнгөөс чөлөөлөх үед захиалагч дараах байдлаар бүртгэнэ.

Дт Байгууллагад төлөх өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(в) гүйцэтгэсэн ажил чанарын шаардлага хангаагүй тохиолдолд захиалагч нь нэмэлт ажил хийлгэх хүсэлтийг гүйцэтгэгчид гаргаж болно. Хүсэлтийн дагуу гүйцэтгэсэн нэмэлт ажлын төлбөрийг барьцаа хөрөнгөөс гаргах үед:

Дт Байгууллагад төлөх өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(г) барьцааны хугацаа дуусахад барьцааны үлдсэн дүнг гүйцэтгэгч рүү шилжүүлэх үед:

Дт Байгууллагад төлөх өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Захиалагчийн хяналт

10.57.Захиалагчийн хяналтыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) захиалагчийн хяналтын төлбөр орж ирэх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Бусад орлого

(б) захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан зардлыг бүртгэх үед:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ БИЕТ БУС ХӨРӨНГӨ

11.1.Биет бус хөрөнгө нь биет шинж чанаргүй, тодорхойлж болох, мөнгөн бус зүйлсийн хөрөнгө юм.

11.2.Биет бус хөрөнгөнд зохиогчийн эрх, программ хангамж, патент, барааны тэмдэг, тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрх, бусад биет бус хөрөнгө зэрэг хамаарна.

11.3.Биет бус хөрөнгийн бүртгэлд УСНББОУС 31 *Биет бус хөрөнгө*, УСНББОУС 21 *Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, УСНББОУС 26 *Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, УСНББОУС 5 *Зээлийн өртөг* -ийг мөрдөнө.

11.4.Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж биет бус хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн хөрөнгийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Биет бус хөрөнгө нь дараах шалгуурыг хангана:

(а) тодорхойлж болох: Хөрөнгө дараах шалгуурын аль нэгийг хангаж байвал тодорхойлж болох хөрөнгө гэж үзнэ:

(i) Салган тусгаарлах, өөрөөр хэлбэл байгууллагаас тусгаарлах буюу салган хувааж болох ба байгууллага тийм санаа зорилготой эсэхээс үл хамааран холбогдох гэрээ, тодорхойлж болох хөрөнгө, өр төлбөрөөс бие даасан байдлаар, эсхүл хамтад нь борлуулах, шилжүүлэх, лицензээр эзэмшүүлэх, түрээслүүлэх, солилцох боломжтой байх;

(ii) Гэрээ болон бусад хуулийн эрхийг шилжүүлж болох буюу байгууллагаас, эсхүл бусад эрх, үүргээс салган тусгаарлаж болох эсэхээс үл хамааран заавал биелүүлэх хэлцлээс үүссэн байх.

(б) хөрөнгийн хяналт: Байгууллага хөрөнгөөс ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхыг авах ба тэрхүү үр өгөөж буюу үйлчилгээний чадавхад бусад этгээд хандан нэвтрэхийг хязгаарлах бүрэн эрхтэй бол хөрөнгийг хянаж байна гэж үзнэ. Биет бус хөрөнгөөс бий болох ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхыг хянах чадвар нь хууль, шүүхийн дагуу хүчин төгөлдөр байх хууль ёсны эрхэд ихэвчлэн үндэслэдэг.

11.5.Байгууллага нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлэхийн тулд хөрөнгийг бий болгох үе шатыг судалгааны ба хөгжүүлэлтийн үе шат гэж ангилаад, дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

(а) судалгааны зардлыг гарсан тухай бүрд нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

(б) хэрэв биет бус хөрөнгийг бий болгох судалгааны үе шатыг хөгжүүлэлтийн үе шатнаас ялгаж чадахгүй байгаа бол зарцуулсан зардлыг зөвхөн судалгааны үе шатанд гарсан гэж үзээд зардлаар хүлээн зөвшөөрнө.

(в) биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй хөгжүүлэлтийн зардлыг гарсан тухай бүрд зардлаар, харин шалгуурыг хангасан тохиолдолд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

11.6.Байгууллага нь дараах шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд хөгжүүлэлтээс бий болох биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө:

(а) хөгжүүлэлтийг бүрэн дуусгах техникийн үндэслэлтэй байх;

(б) биет бус хөрөнгийг бүрэн дуусгах ба түүнийг ашиглах, эсхүл борлуулах зорилготой байх;

(в) ашиглах, эсхүл борлуулах боломжтой байх;

(г) ирээдүйн магадлалт эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг хэрхэн бий болгох;

(д) хөгжүүлэлтийг бүрэн дуусгах ба тухайн биет бус хөрөнгийг ашиглах, эсхүл борлуулах зохих техникийн, санхүүгийн болон бусад нөөц бэлэн боломжтой байх;

(е) хөгжүүлэлтийн явцад уг биет бус хөрөнгөнд хамаарах зарлагыг найдвартай хэмжих чадвар боломжтой байх.

11.7.Үйлдлийн систем (windows, IOS) болон техник хэрэгслийн ажиллагаанд зайлшгүй шаардлагатай программ хангамжийг худалдан авах үед тухайн техник хэрэгслийн өртгийн бүрэлдэхүүнд оруулж, үндсэн хөрөнгөөр бүртгэнэ.

11.8.Программ хангамж нь холбогдох техник хэрэгслийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг биш байх тохиолдолд тусдаа биет бус хөрөнгө гэж үзнэ.

11.9.Программ хангамжтай холбоотой жил тутмын сайжруулалт, ашиглалтын гэрээгээр ашиглаж буй программ хангамжид нэмэлт хөгжүүлэлт хийх, эрх сунгалтын төлбөрийг урсгал засвар, үйлчилгээ гэж үзэн тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

11.10.Худалдан авсан үед биет бус хөрөнгийг өртгөөр нь үнэлж, бүртгэнэ.

11.11.Дотооддоо бий болгосон үед хөгжүүлэлтийн үе шатанд хамаарах зардлын дүнгээр биет бус хөрөнгийг хэмжинэ.

11.12.Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол түүний хорогдуулах дүнг ашиглалтын хугацаанд нь тодорхой аргаар хуваарилж, хорогдуулгын зардалд тусгана.

11.13.Хорогдуулах дүн нь хөрөнгийн анхны өртгөөс үлдэх өртгийг хассан дүн юм. Үлдэх өртөг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст түүнийг данснаас хасахтай холбоотой аливаа зардлыг хассаны дараа байгууллагад орж ирэх дүнг хэлнэ.

11.14.Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн үлдэх өртгийг доор дурдсанаас бусад тохиолдолд тэг (0) гэж үзнэ:

(а) хөрөнгийг түүний ашиглалтын хугацааны эцэст худалдан авах баталгааг гуравдагч тал гаргасан байх

(б) хөрөнгийн хувьд идэвхтэй зах зээл оршин байх ба уг зах зээлийн үнийг үндэслэн үлдэх өртгийг тодорхойлох боломжтой

11.15.Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бус бол үнэ цэнийн бууралт тооцно.

11.16.Биет бус хөрөнгийг худалдан авах, арилжааны бус ажил гүйлгээгээр олж бэлтгэх, бусад хөрөнгөөр солилцох, холбогдох дараа үеийн зардал, дахин үнэлгээний загвар, үнэ цэнийн бууралт, данснаас хасах зэргийг энэ журмын 10 дугаар бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ.

11.17.Биет бус хөрөнгийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) биет бус хөрөнгийг худалдан авах үед:

Дт	Биет бус хөрөнгө /нэр төрлөөр/
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг

(б) хөгжүүлэлтийн үе шатанд байгаа байгууллагын өөрөө бүтээн бий болгож байгаа хөрөнгөтэй холбогдох зардлыг хуримтлуулж бүртгэх үед:

Дт	Биет бус хөрөнгө /нэр төрлөөр/
----	--------------------------------

Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг/ Бараа материал/
Холбогдох бусад данс

(в) тайлангийн үед хамаарах хорогдуулгыг зардалд бүртгэх үед:

Дт Хорогдуулгын зардал

Кт Хуримтлагдсан хорогдуулга

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

12.1.Биологийн хөрөнгө гэдэг нь амьд амьтан, ургамал юм.

12.2.Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах өсөж үржиж, үр жимс, үр төл өгдөг амьд амьтан, ургамал зэрэг нь биологийн хөрөнгөнд багтана.

12.3.УСНББОУС 27 Хөдөө аж ахуй дагуу биологийн хөрөнгийг бүртгэнэ.

12.4.Байгууллага өнгөрсөн үйл явдлын үр дүнд биологийн хөрөнгө, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хянаж, уг хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн өгөөжийг хүртэх магадлалтай, уг хөрөнгийн бодит үнэ цэнэ, өртгийг хэмжих боломжтой тохиолдолд хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийн төрөл	Мөрдөх стандарт	Тайлбар, жишээ	Хэмжилт
Биологийн хөрөнгө	УСНББОУС 27 Хөдөө аж ахуй	Мал амьтад болон үр шим хүртэлтийг хойшлуулсан ойжуулалт, үржүүлгийн зорилгоор ургуулж буй мод, сөөг	Анх удаад болон дараа үед бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгээр (бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын гарзыг хасаж тооцсон өртгөөр)
Биологийн хөрөнгөөс хүлээн авсан бүтээгдэхүүн	УСНББОУС 27 Хөдөө аж ахуй	Ноос, ноолуур, мах, жимс гэх мэт	
Эх ургамал	УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлтгэн нийлүүлэхэд ашиглаж байгаа, нэгээс дээш тайлант үед жимс хураан авахаар хүлээгдэж буй мод, сөөг	
Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд хамааралгүй биологийн хөрөнгө	УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө	Үр шим хүртэхгүй, үр шим хүртэлтийг удирдахгүй, үйлчилгээ үзүүлэх зорилгоор эзэмшиж буй (уналга, эдэлгээнд ашиглах мал амьтад, замын хажуугийн болон хот суурин газрын ногоон байгууламжийн мод, сөөг гэх мэт)	Анх удаад өртгөөр, дараа үед өртгийн, эсхүл дахин үнэлгээний загвараар

12.5.Байгууллага өөрийн эзэмшиж буй эх ургамлыг үндсэн хөрөнгө гэж бүртгэнэ.

12.6.Байгууллага хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсний үр дүнд эх ургамлаас биологийн хувьслын улмаас бий болсон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бараа материал гэж бүртгэнэ.

12.7.Бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байгаагаас бусад бүх тохиолдолд биологийн хөрөнгийг анх хүлээн авах үед болон тайлангийн хугацааны эцэс бүрд борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ.

12.8.Биологийн хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтөөс бий болох олз буюу гарзыг тэдгээрийн үүссэн тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусгана. Хөдөө аж ахуйн биржийн мэдээллийг ашиглан дараах шатлалын дагуу бодит үнэ цэнийг хэмжиж болно. Үүнд:

(а).хөдөө аж ахуйн бирж дээрх тухайн хөрөнгийн дундаж үнэ /сар, улирлаар гаргаж буй дүн/;

(б).тухайн хөрөнгийн хөдөө аж ахуйн бирж дээрх үнийг сар, улирлаар мэдэх боломжгүй үед бирж дээрх уг хөрөнгөд хамаарах хамгийн сүүлчийн ажил гүйлгээний үнэ;

(в).хөдөө аж ахуйн бирж дээрх ижил төрлийн хөрөнгийн дундаж үнэ /зөрүүг тохируулсан/;

(г).салбарын жишиг үнэ;

(д).тухайн хөрөнгийг цаашид ашигласнаар ирээдүйд бий болохоор тооцсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ.

12.9.Бодит үнэ цэнэ нь зах зээл дээрх үнийн ба биет өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөгддөг. Биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлт нь нэг тайлант үеэс дараагийн тайлант үеийн үнэ цэнийн хоорондох зөрүүг илэрхийлнэ. Уг үнэ цэнэ нь ургамлын ургалт, малын үржил, үнийн өсөлт зэргээс шалтгаалан нэмэгддэг боловч хөгшрөх, муудах, өвчлөх, үнийн уналтаас шалтгаалж буурна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах үед биш харин түүний өсөлт, эсхүл нас дэвшилт болох үед энэ өөрчлөлтийг орлогоор хүлээн зөвшөөрнө.

12.10.Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дараах хүчин зүйлийн улмаас өөрчлөгддөг. Үүнд:

(а).мал сүргийн хорогдол ба төрөлт–Биологийн хөрөнгө хувьсан өөрчлөгдөхийн хэрээр зарим хөрөнгө хорогдох, эсхүл устах магадлалтай.

(б).өсөлт бойжилтоос үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт – Өсөлт бойжилтын улмаас бодит үнэ цэнэ өөрчлөгдөнө.

(в).үнийн өөрчлөлтөөс үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт

12.11.Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын гарзыг хасаж тооцсон өртгөөр хэмжинэ. Харин уг биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжих боломжтой болмогц борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ.

12.12.Биологийн хөрөнгийг худалдан авах, арилжааны бус ажил гүйлгээгээр олж бэлтгэх, бусад хөрөнгөөр солилцох, данснаас хасахдаа энэ журмын 10 дугаар бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ.

12.13.Биологийн хөрөнгийн хувьд нийтлэг дараах бичилт хийнэ:

(а) биологийн хөрөнгө худалдан авах үед:

Дт Биологийн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг

(б) биологийн шинэ хөрөнгө буюу төл хүлээн авсан үед:

Дт Биологийн хөрөнгө – Төл мал
Кт Бусад орлого

(в) биологийн хөрөнгийн нас дэвшилтээр үнэлгээ өссөн үед:

Дт Биологийн хөрөнгө
Кт Бодит үнэ цэнийн үнэлгээний олз

(г) биологийн хөрөнгийн нас дэвшилтээр үнэлгээ буурсан үед:

Дт Бодит үнэ цэнийн үнэлгээний гарз
Кт Биологийн хөрөнгө

(д) мод, сөөгийг ургуулахтай холбогдон тайлант үеийн гарсан зардлыг бүртгэхдээ:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Өглөг

(е) мод, сөөгийн амьдрах чадварыг тодорхойлсон мэргэжлийн байгууллага, иргэний гаргасан дүгнэлт, акт болон бусад баримтад үндэслэн амьдрах чадвар нь 70-80% -д хүрсэн тарьц, суулгацыг биологийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Дт Биологийн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Бодит үнэ цэнийн үнэлгээний олз

(ё) хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хүлээн авах үед:

Дт Бараа материал /нэр төрлөөр/
Кт Бодит үнэ цэнийн үнэлгээний олз

(ж) тайлант үеийн эцэст биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс бий болсон үнэлгээний нэмэгдлийг бүртгэх үед:

Дт Биологийн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Бодит үнэ цэнийн үнэлгээний олз

(з) тайлант үеийн эцэст биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс бий болсон үнэлгээний бууралтыг бүртгэх үед:

Дт Бодит үнэ цэнийн үнэлгээний гарз
Кт Биологийн хөрөнгө /нэр төрлөөр/

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, БОРЛУУЛАХ ЗОРИЛГООР ЭЗЭМШИЖ БУЙ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

13.1.Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь өөрийн үйл ажиллагаанд ашиглахгүй, түрээсийн орлогоор, эсхүл хөрөнгийн үнийн өсөлтөөр, эсхүл энэ хоёрын аль алианаар ашиг олохын тулд эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийг хэлнэ.

13.2.Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд УСНББОУС 16 *Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө*, УСНББОУС 21 *Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт*, УСНББОУС 26 *Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт* -ыг мөрдөнө.

13.3.Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, энэ журмын 13.1-д заасан тодорхойлолтод нийцсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

13.4.Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь хэмжиж, бүртгэнэ.

13.5.Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнийн загвар болон өртгийн загварын аль нэгийг сонгон бүртгэнэ. Сонгосон загвараа үйл ажиллагааны түрээсийн хөрөнгөөс бусад хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгөнд ашиглана.

13.6.Хэрэв хөрөнгийг өртгийн загвараар бүртгэсэн бол өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны үнээр, бодит үнэ цэнийн загвараар бүртгэсэн бол бодит үнэ цэнээр санхүүгийн байдлын тайланд толилуулна.

13.7.Үйл ажиллагааны түрээсээр түрээслэгчийн эзэмшиж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнийн загвараар бүртгэнэ.

13.8.Хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй үед өртгийн загвараар хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг хэмжинэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үлдэх өртгийг тэг гэж үзнэ.

13.9.Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг худалдан авах, арилжааны бус ажил гүйлгээгээр олж бэлтгэх, бусад хөрөнгөөр солилцох, холбогдох дараа үеийн зардал, өртгийн загвар, үнэ цэнийн бууралт, данснаас хасах зэргийг энэ журмын 10 дугаар бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ.

13.10.Бодит үнэ цэнийн загвараар бүртгэсэн хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтөөс бий болсон олз, гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

13.11.Борлуулах зориулалттай хөрөнгө гэж эргэлтийн бус хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш, харин борлуулах ажил гүйлгээгээр түүний дансны үнийг нөхөх эргэлтийн бус хөрөнгийг хэлнэ.

13.12.Байгууллага нь борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгийг түүний дансны үнэ ба борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар хэмжинэ.

13.13.Хөрөнгийг худалдааны хэвийн нөхцөлөөр одоогийн байдлаар нь худалдан борлуулах боломжтой бөгөөд хөрөнгийг худалдан авах магадлал өндөр байх үед борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

13.14.Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг борлуулах тохиолдолд олз, гарзыг тухайн үл хүлээн зөвшөөрөлтийн өдөр хүлээн зөвшөөрнө. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөнд элэгдэл тооцохгүй.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

14.1.Санхүүгийн өр төлбөрийг УСНББОУС 28 *Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга*, УСНББОУС 29 *Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*, УСНББОУС 30 *Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга*-ийн дагуу бүртгэнэ.

14.2.Төсвийн байгууллага нь зөвхөн эрх бүхий байгууллагын шийдвэртэйгээр зээл авах, түүнтэй адилтгах төлбөрийн хариуцлага үүсгэнэ.

14.3.Санхүүгийн өр төлбөрийг дараах байдлаар ангилж, бүртгэнэ:

(а) хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн өр төлбөр;

(б) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих санхүүгийн өр төлбөр.

14.4.Санхүүгийн өр төлбөрийн хэмжилт, толилуулга нь ангилал тус бүрд ялгаатай байдгийг доорх нэгтгэн харуулав:

Үзүүлэлт	Хорогдуулсан өртгөөр хэмжих	Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих
Анхны хэмжилт	Бодит үнэ цэнэ	Бодит үнэ цэнэ
Ажил гүйлгээний өртөг	Анхны үнэлгээг бууруулна	Зардалд бүртгэнэ
Дараагийн тайлант үеийн хэмжилт	Хорогдуулсан өртөг	Бодит үнэ цэнэ
Дараагийн тайлант үеийн үнэлгээний өөрчлөлтийг бүртгэх	-	Ашиг, алдагдал
Хорогдуулсан дүнг бүртгэх	Ашиг, алдагдал	-

14.5.Санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжих ба үүнд ажил гүйлгээний өртөг багтах эсэх нь түүний ангиллаас хамаарна.

14.6.Санхүүгийн өр төлбөр, түүний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой хүү, олз, гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Зээлийн өр төлбөр

14.7.Зээлийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) зээл авах үед өр төлбөр үүсгэн бүртгэнэ:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Зээл

(б) урт хугацаат зээлийн тайлант үеийн төлөгдөх хэсгийг богино хугацаат зээлийн дансанд шилжүүлж бүртгэхдээ:

Дт Урт хугацаат зээл
Кт Богино хугацаат зээл

(в) зээлийн хүүг хуримтлуулан бүртгэх үед:

Дт Хүүгийн зардал
Кт Хүүгийн өглөг

(г) зээлийн хүүг төлж барагдуулах үед:

Дт Хүүгийн өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(д) зээлийг төлж барагдуулах үед:

Дт Зээл
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Үнэт цаас

14.8.Үнэт цаасыг дараах байдлаар бүртгэнэ:

(а) үнэт цаас гаргах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Үнэт цаас

(б) үнэт цаасыг хөнгөлөлттэй гаргах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Дт Үнэт цаасны хөнгөлөлт
Кт Үнэт цаас

(в) үнэт цаасны хөнгөлөлтийг хорогдуулсан дүнгээр хүүгийн зардлыг нэмэгдүүлж тохируулан бүртгэх үед:

Дт Хүүгийн зардал
Кт Үнэт цаасны хөнгөлөлт

(г) үнэт цаасыг урамшуулалтай гаргах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Үнэт цаасны урамшуулал
Кт Үнэт цаас

(д) үнэт цаасны урамшууллыг хорогдуулсан дүнгээр хүүгийн зардлыг бууруулж тохируулан бүртгэх үед:

Дт Үнэт цаасны урамшуулал
Кт Хүүгийн зардал

(е) үнэт цаасны хүүг төлсөн эсэхээс үл хамааран хуримтлуулан бүртгэнэ.

Дт Хүүгийн зардал
Кт Хүүгийн өглөг

(ё) урт хугацаат үнэт цаасны тайлант үеийн төлөгдөх хэсгийг богино хугацаат үнэт цаасны дансанд шилжүүлж бүртгэх үед:

Дт Урт хугацаат үнэт цаас
Кт Богино хугацаат үнэт цаас

(ж) үнэт цаасыг төлж барагдуулах үед:

Дт Үнэт цаас
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

14.9.Арилжааны ажил гүйлгээгээр бий болсон өглөгийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) худалдан авсан хөрөнгийн үнийг дараа төлөхөөр тооцоо үүсгэсэн үед:

Дт Хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг

(б) бараа, ажил үйлчилгээний үнийг дараа төлөхөөр тооцоо үүсгэсэн үед:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Бараа, ажил үйлчилгээний өглөг

(в) бэлтгэн нийлүүлэгчид төлөх өр төлбөрийг барагдуулсан үед:

Дт Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг/ Бараа, ажил үйлчилгээний өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

14.10.Ажил үйлчилгээг гүйцэтгэж, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж хүлээн авсан тохиолдолд урьдчилж орсон орлого дансанд төлсөн дүнгээр бүртгэж, цаашид ажил гүйлгээг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн үед орлогоор хүлээн зөвшөөрнө.

(а) урьдчилж орсон орлогыг хүлээн авах үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Урьдчилж орсон орлого

(б) урьдчилж орсон орлогыг хэрэгжсэн үед холбогдох орлогоор хүлээн зөвшөөрсөн бол:

Дт Урьдчилж орсон орлого
Кт Орлого /нэр төрлөөр/

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

15.1.Ажилтны тэтгэмж нь ажил эрхлэлт болон ажлаас халагдсантай холбогдуулан байгууллагаас олгож буй бүх төрлийн төлбөр, урамшуулал юм. Үүнд цалин хөлс, тэтгэмж, шагнал урамшуулал, бусад олговор хамрагдана.

15.2.Ажилтны бүх төрлийн тэтгэмжийг УСНББОУС 39 *Ажилтны тэтгэмж* - ийн дагуу бүртгэнэ.

15.3.Ирээдүйд эдийн засгийн нөөцийг бууруулж, гадагшлах магадлалтай бөгөөд үр дүнг найдвартай хэмжих боломжтой нөхцөлд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

15.4.Өр төлбөрийг ирээдүйд төлөх дүнгээр хэмжиж бүртгэнэ.

15.5.Урт хугацаат өр төлбөрийг ирээдүйн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр буюу дискаунтчилсан дүнгээр хэмжинэ.

15.6.Өр төлбөрийг төлж барагдуулсан, үүргээс чөлөөлөгдсөн, хугацаа дуусгавар болсон үед данснаас хасаж, үл хүлээн зөвшөөрнө.

Ажилтны богино хугацааны тэтгэмж

15.7. Ажилтны богино хугацааны тэтгэмж нь ажилтны тухайн байгууллагад ажилласан тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор бүрэн барагдуулахаар хүлээгдэж буй тэтгэмж юм.

Тэтгэмжийн төрөл		Хүлээн зөвшөөрөлт	Хэмжилт
1.Богино хугацааны бүх төрлийн тэтгэмж		Ажилтан гэрээгээр заасан үүргээ биелүүлсэн үед (УСНББОУС 39.11)	- Дискаунтчилаагүй төлөх дүнгээр зардал бүртгэнэ. - Олгоогүй дүнгээр өр төлбөр бүртгэнэ. - Илүү төлсөн дүнгээр урьдчилж төлсөн тооцоог бүртгэнэ.
2.Цалинтай чөлөө	Хуримтлагдах	Ажилтан чөлөө авах эрх үүсгэх нөхцөл хангасан үед (УСНББОУС 39.13(а))	Хүлээгдэж буй зардлын дүнгээр өр төлбөр бүртгэнэ.
	Үл хуримтлагдах	Ажилтан чөлөө авсан үед (УСНББОУС 39.13(б))	Төлөх дүнгээр зардал, өр төлбөр бүртгэнэ.
3.Шагнал, урамшуулал		Байгууллага хуулийн, эсхүл гэрээний бус үүрэг хүлээсэн ба уг үүргийг найдвартай хэмжих боломжтой үед (УСНББОУС 39.19)	Төлөх дүнгээр зардал, өр төлбөр бүртгэнэ.

15.8.Байгууллага нь ажилтны гүйцэтгэсэн ажил, ажилласан цагт үндэслэн богино хугацааны тэтгэмжийг дискаунтчилаагүй төлөх дүнгээр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Ажилтны урт хугацааны тэтгэмж

15.9.Ажилтны урт хугацааны тэтгэмжид ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болон бусад урт хугацаат тэтгэмж хамрагдана.

Тэтгэмжийн төрөл		Хүлээн зөвшөөрөлт	Хэмжилт
1.Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж	Тогтоосон шимтгэлийн хөтөлбөр	Ажилтан гэрээгээр заасан үүргээ биелүүлсэн үед (УСНББОУС 39.53)	- Төлөх дүнгээр зардал, өр төлбөр бүртгэнэ (дискаунтчилахгүй) - Тэтгэврийн сангийн шимтгэлийг 12 сараас урт хугацаанд төлөхөөр бол дискаунтчилж болно.
	Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр	Ажилтан гэрээгээр заасан үүргээ биелүүлсэн үед (УСНББОУС 39.57)	- Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр буюу хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. - Төлбөрийн үүрэг болон зардлыг хэмжихэд актуар төсөөлөл хийх бөгөөд актуар олз, гарз бүртгэнэ. - Санхүүжилтгүй, санхүүжилттэй, эсхүл хагас санхүүжилттэй байж болно. - Хөтөлбөрийн өр төлбөрийг дискаунтчилсан дүнгээр хэмжинэ. - Хөтөлбөрийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжинэ.
2.Урт хугацааны бусад тэтгэмж		- Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжтэй адил - 12 сарын дотор бүрэн барагдуулахгүй (УСНББОУС 39.155)	- Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжтэй адил. - Хялбаршуулсан арга ашиглана.

Ажилтны богино хугацааны тэтгэмж

15.10.Ажилтны богино хугацааны бүх төрлийн тэтгэмжийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) ажилтнуудад төлөхөөр тооцоолсон тэтгэмж, шагнал, урамшууллын дүнгээр зардал, өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Дансны өглөг /нэр төрлөөр/

(б) ажилтнуудад тэтгэмж, шагнал, урамшууллыг олгох үед:

Дт Дансны өглөг /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

15.11.Ажилтны цалин хөлс, олговрыг энэ журмын 3.5-д заасны дагуу бүртгэнэ.

Ажилтны урт хугацааны тэтгэмж

15.12.Ажилтны урт хугацааны тэтгэмжийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) хүлээгдэж буй төлбөрийн дүнгээр зардлыг хуримтлуулан өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх үед:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Бусад урт хугацаат өр төлбөр

(б) ирээдүйн төлбөрийн дискаунчилсан дүнгээс хүүгийн зардал хүлээн зөвшөөрч, бүртгэх үед:

Дт Хүүгийн зардал
Кт Бусад урт хугацаат өр төлбөр

(в) урт хугацааны тэтгэмжийн сангаас ажилтанд тэтгэмж олгох үед:

Дт Бусад урт хугацаат өр төлбөр

**АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ
НӨӨЦ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ**

16.1.Нөөц нь төлөх цаг хугацаа болон дүн тодорхой бус өр төлбөр юм.

16.2.Болзошгүй өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн, төлөх дүн мэдэгдэхгүй байгаа, эсхүл төлөх магадлал багатай үүрэг юм.

16.3.Болзошгүй хөрөнгө нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг бөгөөд түүний оршин байдал нь байгууллагын хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын тохиолдол, эсхүл үл тохиолдлоор батлагдах боломжтой хөрөнгө юм.

16.4.Нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгийн бүртгэлд УСНББОУС 19 *Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө* -ийг мөрдөнө.

16.5.Байгууллага нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулиар хүлээсэн болон гэрээний бус одоогийн үүрэгтэй, дүнг нь найдвартай тооцох боломжтой бөгөөд уг үүргийг барагдуулахад хөрөнгө зарцуулах магадлалтай үед нөөцийг хүлээн зөвшөөрнө.

16.6.Хэрэв дээрх нөхцөлүүд хангагдахгүй бол нөөц хүлээн зөвшөөрөхгүй, болзошгүй өр төлбөр гэж тодруулна.

16.7.Болзошгүй хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй, зөвхөн тодруулна.

16.8.Байгууллага ямар нэг байдлаар алдагдалтай гэрээ байгуулсан бол тус гэрээний дагуу үүссэн одоогийн үүрэг хариуцлагыг нөөцөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

16.9.Хэрэв байгууллагын тасралтгүй үйл ажиллагаа алдагдсан буюу байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдсэн бол түүнээс үүсэх шууд зарлагыг агуулсан бүтцийн өөрчлөлтийн нөөц байгуулж, ашиглана.

16.10.Нөөцөөр хүлээн зөвшөөрсөн дүн нь тайлангийн өдрөөр уг одоогийн үүргийг барагдуулахад шаардлагатай зарлагын хамгийн сайн тооцоолол байна. Хамгийн сайн тооцооллыг хийхийн тулд олон үйл явдал, нөхцөлд байнга тохиолддог эрсдэл, тодорхойгүй байдлыг харгалзаж үзэхийн зэрэгцээ мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ материаллаг нөлөөтэй бол үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах хүлээгдэж буй зардлын өнөөгийн үнэ цэнийг тооцно.

16.11.Нөөцийн дүнг тайлангийн өдрөөр нягтлах бөгөөд хамгийн сайн тооцооллыг тусгаж, тохируулна.

16.12. Нөөцийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) нөөцийг байгуулах болон нэмэгдүүлэх үед:

Дт	Зардал /нэр төрлөөр/
Кт	Нөөц /өр төлбөр/

(б) нөөцийг тодорхой зарлагад зориулж ашиглах буюу анх нөөц гэж хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн тэр зорилгоор ашиглана. Нөөцийг зориулалтын дагуу зарцуулах үед:

Дт	Нөөц /өр төлбөр/
Кт	Хөрөнгө /нэр төрлөөр/

(в) үүргийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний боломж бүхий хөрөнгийг зарцуулах магадлал бага бол нөөцийн дүнг буцаана. Нөөцийн буцаалтыг бүртгэх үед:

Дт Нөөц /өр төлбөр/
Кт Зардал /нэр төрлөөр/, эсхүл Бусад олз

АРВАН ДОЛООДУГААР БҮЛЭГ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ

17.1.Цэвэр хөрөнгө/өмч нь байгууллагын нийт хөрөнгийн дүнгээс бүх өр төлбөрийн дүнг хассаны дараа үлдэх хувь оролцоог хэлнэ.

17.2.Засгийн газрын хяналтын хувь оролцоо нь оруулсан хөрөнгө, хуримтлагдсан үр дүн, бусад цэвэр хөрөнгө/өмчөөс бүрдэнэ.

17.3.Байгууллага нь зөвхөн дараах тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилнө. Үүнд:

(а) өөрчлөлтийг УСНББОУС-аар шаардсан;

(б) өөрчлөлт нь тухайн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд ажил гүйлгээ, бусад үйл явдал болон нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөний талаар үнэн зөв илэрхийлэх ба илүү хамааралтай мэдээллээр хангах үр дүнг санхүүгийн тайланд бий болгоно.

17.4.Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөд нягтлан бодох бүртгэлийн арга зарчмаа өөрчлөхгүйгээр, шинэ мэдээлэл, шинэ туршлагын үр дүнд тооцооллыг өөрчлөх өөрчлөлтийг хамааруулна.

17.5.Тооцооллын өөрчлөлтийн нөлөөг дараах байдлаар тайлагнана:

(а) хэрэв өөрчлөлт нь зөвхөн тайлант үедээ нөлөө үзүүлдэг бол өөрчлөлт гарсан уг тайлант үед нь;

(б) хэрэв өөрчлөлт нь өөрчлөлт гарсан тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдийн аль алинд нөлөө үзүүлдэг бол өөрчлөлт гарсан уг тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд нь тайлагнана.

17.6.Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт нь хөрөнгө, өр төлбөрийг өөрчилдөг, эсхүл цэвэр хөрөнгө/өмчийн зүйлд хамааралтай бол холбогдох хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дансны үнийг тохируулах замаар уг өөрчлөлт гарсан тайлант үед хүлээн зөвшөөрнө.

17.7.Байгууллага нь өмнөх тайлант үеийн материаллаг алдааг буцаах горимоор засварлана. Харин тайлант үед хамаарах бүртгэлийн алдааны залруулгыг харгалзах тайлант үеийн орлого, зардал, олз, гарзыг тохируулж бүртгэнэ.

17.8.Буцаах горим гэж нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг анхнаас нь мөрдөж байсан бол ямар байх байсан тийм байдлаар ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдалд даган мөрдөхийг хэлнэ.

17.9.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө нь өмнөх тайлант үед хамаарах тохиолдолд хуримтлагдсан үр дүн дансны эхний үлдэгдлийг тохируулна.

17.10.Цэвэр хөрөнгө буюу өмчийн дансны өөрчлөлтийг дараах байдлаар бүртгэнэ:

(а) засгийн газраас оруулсан хувь оролцоог нэмэгдүүлэх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Бусад холбогдох хөрөнгийн данс

Кт Засгийн газрын хувь оролцоо - Оруулсан хөрөнгө

(б) засгийн газраас хувь оролцоогоо татан авах үед:

Дт Засгийн газрын хувь оролцоо - Оруулсан хөрөнгө

Кт Хөрөнгө /нэр төрлөөр/

(в) тайлант үед ашигтай ажилласан үед:

Дт Орлого, зарлагын нэгдсэн данс

Кт Тайлант үеийн үр дүн

(г) тайлант үед алдагдалтай ажилласан үед:

Дт Тайлант үеийн үр дүн

Кт Орлого, зарлагын нэгдсэн данс

(д) үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнд бий болсон дансны үнийн өсөлтийг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ:

Дт Хөрөнгө /нэр төрлөөр/

Кт Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

(е) нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгаар хуримтлагдсан үр дүн дансны эхний үлдэгдлийг нэмэгдүүлэх үед:

Дт Холбогдох хөрөнгө, өр төлбөр, өмчийн данс

Кт Өмнөх үеийн үр дүн

(ё) нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгаар хуримтлагдсан үр дүн дансны эхний үлдэгдлийг бууруулах үед:

Дт Өмнөх үеийн үр дүн

Кт Холбогдох хөрөнгө, өр төлбөр, өмчийн данс

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ ТҮРЭЭС

18.1.Түрээс гэдэг нь нэг төлбөр буюу цуврал төлбөрүүдийн хариуд түрээслүүлэгч нь тухайн хөрөнгийг тохиролцсон хугацаагаар ашиглах эрхийг түрээслэгчид шилжүүлдэг гэрээ юм.

18.2.Төсвийн байгууллага нь бусдын хөрөнгийг түрээсэлж авсан бол ашиглах эрхтэй хөрөнгийг үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө эсхүл бусад хөрөнгөөр, түрээсийн өр төлбөрийг хугацааг нь харгалзан богино эсхүл урт хугацаат өр төлбөрөөр бүртгэж, тайлагнана.

18.3.Түрээслүүлэгчийн хувьд түрээсийг санхүүгийн түрээс ба үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Санхүүгийн түрээс нь суурь хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бараг бүх эрсдэл болон урамшууллыг шилжүүлэх нөхцөл бүхий түрээс юм.

18.4.Түрээсийн бүртгэлд УСНББОУС 43 Түрээс -ийг мөрдөнө.

Түрээслэгч

18.5.Байгууллага санхүүгийн түрээсээр ашиглах эрхтэй хөрөнгө олж эзэмшсэн тохиолдолд санхүүгийн түрээсийн хөрөнгө, өр төлбөрийг түрээсийн эхэнд

тодорхойлсон түрээсийн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар хэмжинэ. Энэхүү тооцоонд ашиглах хүүгийн түвшин нь нуугдмал хүү ба зах зээлийн хүүгийн аль бага байна.

Дт Хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Түрээсийн өглөг

18.6.Түрээсийн өр төлбөрийг тайлант үе бүрд санхүүгийн зардал буюу хүүгийн зардал болон өр төлбөрийн бууралтад хуваарилна.

(а) түрээсийн өр төлбөрт харгалзах хүүг тооцоолон бүртгэх үед:

Дт Хүүгийн зардал
Кт Түрээсийн өглөг

(б) түрээсийн төлбөр төлөх үед:

Дт Түрээсийн өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(в) түрээсийн хөрөнгийн татвар болон бусад зардлыг төлөх үед:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

18.7.Ашиглах эрхтэй хөрөнгийг ижил төстэй хөрөнгөд баримталдаг бодлогын дагуу элэгдүүлнэ. Хэрэв түрээслэгч нь түрээсийн хугацааны эцэст түрээсийн хөрөнгийг өмчлөх эрхтэй бол тухайн хөрөнгийн ашиглахаар тооцсон хугацаанд, харин тийм эрх үүсээгүй бол ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаанд бүрэн элэгдүүлнэ.

(а) ашиглах эрхтэй хөрөнгийг элэгдүүлэх үед:

Дт Элэгдлийн зардал
Кт Хуримтлагдсан элэгдэл

(б) түрээсийн хугацааны төгсгөлд хөрөнгийг түрээслүүлэгчид буцаан өгөх үед:

Дт Хуримтлагдсан элэгдэл
Кт Хөрөнгө /нэр төрлөөр/

18.8.Богино хугацаат болон бага үнэтэй суурь хөрөнгийн түрээсийн хувьд ашиглах эрхтэй хөрөнгө, түрээсийн өр төлбөр бүртгэхгүй ба харин түрээстэй холбоотой төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын сууриар зардалд хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Түрээслүүлэгч: Санхүүгийн түрээс

18.9.Түрээсийн хугацааны эхэнд түрээслүүлэгч санхүүгийн түрээсийн авлагыг түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцүү хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Цэвэр хөрөнгө оруулалтыг тооцоолохдоо нуугдмал хүүгийн түвшинг ашиглана.

Дт Түрээсийн авлага
Кт Хөрөнгө борлуулсны олз
Кт Хөрөнгө /нэр төрлөөр/

18.10.Дараа үед түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтаас тогтмол өгөөжийн түвшнийг ашиглан тооцоолсон санхүүгийн орлого буюу хүүгийн орлогыг түрээсийн хугацаанд хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

(а) түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтаас хүүгийн орлого тооцоолсон үед:

Дт Түрээсийн авлага
Кт Хүүгийн орлого

(б) түрээсийн төлбөр төлөгдөх үед авлагыг бууруулна:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Түрээсийн авлага

Түрээслүүлэгч: Үйл ажиллагааны түрээс

18.11.Байгууллага үйл ажиллагааны түрээсээр хөрөнгөө бусдад түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн төлбөр тайлант үе бүрд төлөгдөж байгаа бол тухайн тайлант үеийн орлогоор, харин түрээсийн төлбөр урьдчилан бөөн дүнгээр төлөгдсөн бол шулуун шугамын аргаар орлого болгон хүлээн зөвшөөрнө.

(а) үйл ажиллагааны түрээсийн төлбөр төлөгдөх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Түрээсийн орлого

(б) үйл ажиллагааны түрээсийн төлбөр хараахан төлөгдөөгүй боловч түрээсийн хугацаа өнгөрсөн бол авлага үүсгэнэ:

Дт Авлага /нэр төрлөөр/
Кт Түрээсийн орлого

(в) үйл ажиллагааны түрээсийн төлбөр урьдчилан төлөгдөх үед:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Урьдчилж орсон орлого

(г) тайлант үеийн эцэст урьдчилан төлсөн түрээсийн төлбөрийг орлогод хуваарилж, хүлээн зөвшөөрөх үед:

Дт Урьдчилж орсон орлого
Кт Түрээсийн орлого

(д) түрээсийн төлбөрийн тодорхой хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлэхээр тооцсон үед:

Дт Төсвийн байгууллага хоорондын мөнгөн шилжүүлэг
Кт Дансны өглөг /нэр төрлөөр/

(е) төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төлбөрийг шилжүүлсэн үед:

Дт Дансны өглөг /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ

19.1.Үйлчилгээний концессын хэлцэл нь төсвийн байгууллага (эрх бүхий этгээд)-ын нэрийн өмнөөс төрийн үйлчилгээг үзүүлэхийн тулд эзэмшигч нь уг үйлчилгээний концессын хөрөнгийг тодорхой хугацаанд ашиглах ба энэ хугацаанд түүний үзүүлсэн үйлчилгээний төлөө эзэмшигчид төлбөр олгох нөхцөлтэйгөөр байгуулсан гэрээ юм.

19.2.Үйлчилгээний концессын хэлцэлд авто зам, гүүр, туннел, эмнэлэг, нисэх онгоцны буудал, ус түгээх байгууламж, эрчим хүчний хангамж, харилцаа холбооны сүлжээ, цэргийн болон бусад үйл ажиллагаанд зориулсан байгууламж, төрийн

үйлчилгээг үзүүлэхийн тулд захиргааны зорилгоор ашиглах бусад биет ба биет бус хөрөнгө хамаарна.

19.3. Үйлчилгээний концессын хөрөнгө, өр төлбөрийг УСНББОУС 32 *Үйлчилгээний концессын хэлцэл: Эрх бүхий этгээд* -ийн дагуу бүртгэнэ.

Концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

19.4. Төсвийн байгууллага нь дараах тохиолдолд эзэмшигчийн нийлүүлсэн хөрөнгө ба өөрийн одоо байгаа хөрөнгийн сайжруулалтыг үйлчилгээний концессын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө:

(а). эзэмшигч тухайн хөрөнгөөр ямар үйлчилгээг, хэнд ямар үнээр үзүүлэхийг төсвийн байгууллага хянадаг буюу зохицуулдаг,

(б). төсвийн байгууллага нь үр шимийг хүртэх эрх болон тухайн гэрээний хугацаа дуусахад уг хөрөнгөнд үлдэх аливаа мэдэгдэхүйц хувь оролцоог өмчлөлөөр дамжуулан, эсхүл бусад арга замаар хянадаг.

19.5. Төсвийн байгууллагын хөрөнгө нь хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байвал тэрхүү хөрөнгийг үйлчилгээний концессын хөрөнгө гэж дахин ангилна.

19.6. Хэрэв барьж байгуулсан, эсхүл хөгжүүлсэн хөрөнгө нь үйлчилгээний концессын хөрөнгийн нөхцөлүүдийг хангаж байвал хүлээн зөвшөөрөх шалгуурыг үндсэн хөрөнгө, эсхүл биет бус хөрөнгийн шалгуураар тогтооно.

19.7. Үйлчилгээний концессын хөрөнгийг бодит үнэ цэнээр анх хэмжинэ.

19.8. Үйлчилгээний концессын хөрөнгийн элэгдэл тооцолт, үнэ цэнийн бууралт, данснаас хасалт буюу үл хүлээн зөвшөөрөлт зэргийг энэ журмын 10 дугаар бүлэгт заасны дагуу хэмжиж, бүртгэнэ.

Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

19.9. Үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд мөн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

19.10. Үйлчилгээний концессын өр төлбөрийг үйлчилгээний концессын хөрөнгөтэй ижил дүнгээр анх хэмжих бөгөөд төсвийн байгууллагаас эзэмшигчид өгсөн, эсхүл эзэмшигчээс авсан төлбөрийн дүнгээр тохируулна.

19.11. Төсвийн байгууллагын эзэмшиж буй хөрөнгийг үйлчилгээний концессын хөрөнгө гэж дахин ангилсан бол өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй.

19.12. Үйлчилгээний концессын хөрөнгийн хариуд тухайн эзэмшигчид мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг төлөх нөхцөлт бус үүрэгтэй тохиолдолд санхүүгийн өр төлбөр бүртгэнэ. Энэ тохиолдолд төлбөрийг эзэмшигчид хуваарилж, өр төлбөрийн бууралт, эзэмшигчийн үзүүлсэн үйлчилгээний төлбөр, санхүүгийн зардалд хуваарилж, бүртгэнэ.

19.13. Үйлчилгээний концессын хөрөнгийн хариуд мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг төлөх нөхцөлт бус үүрэггүй бөгөөд гуравдагч талын хэрэглэгчдээс, эсхүл орлого бий болгох бусад хөрөнгөөс орлого олох эрхийг тэрхүү эзэмшигчид олгодог тохиолдолд өр төлбөрийг эрх бүхий этгээд ба эзэмшигчийн хоорондох хөрөнгийн солилцооноос үүссэн орлогын урьдчилж орсон хэсэг байдлаар тайлагнана. Энэ тохиолдолд үйлчилгээний концессын хэлцлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан орлогыг хүлээн зөвшөөрөх ба энэ хэмжээгээр өр төлбөрийг бууруулна.

19.14. Дээрх хоёр нөхцөлийг хамтад нь агуулсан холимог хэлцлийн хувьд хүлээн зөвшөөрсөн нийт өр төлбөрийн хэсэг бүрийг тусад нь бүртгэнэ.

Санхүүгийн өр төлбөрийн загвар

19.15.Үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд цуврал төлбөрүүдийг шилжүүлэх замаар барилгын ажлын нөхөн төлбөрийг хийж байгаа үед өр төлбөрийн загвараар бүртгэнэ:

(а) хөрөнгийг анх хүлээн зөвшөөрч бүртгэх үед:

Дт Үйлчилгээний концессын хөрөнгө
Кт Санхүүгийн өр төлбөр /нэр төрлөөр/

(б) үйлчилгээний концессын хэлцлийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үед:

Дт Санхүүгийн өр төлбөр /нэр төрлөөр/
Дт Хүүгийн зардал
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(в) үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх үед:

Дт Зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Концесс эзэмшигчид эрх олгох загвар

19.16.Хэрэглэгчдээс орлого цуглуулах эрхийг олгох замаар барилгын ажлын нөхөн төлбөрийг хийж байгаа үед концесс эзэмшигчид эрх олгох загвараар бүртгэнэ:

(а) хөрөнгийг анх хүлээн зөвшөөрч бүртгэх үед:

Дт Үйлчилгээний концессын хөрөнгө
Кт Хойшлогдсон орлого

(б) орлогыг хүлээн зөвшөөрөх үед өр төлбөрийг бууруулна:

Дт Хойшлогдсон орлого
Кт Орлого /нэр төрлөөр/

ХОРЬДУГААР БҮЛЭГ ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

20.1.Гадаад валютаар гарсан ажил гүйлгээ, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс, гадаад үйл ажиллагааг УСНББОУС 4 *Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө* -ийн дагуу бүртгэнэ.

20.2.Гадаад валютаарх ажил гүйлгээ нь гадаад валютаар хийгдсэн, эсхүл гадаад валютаар төлбөр тооцоог барагдуулахыг шаарддаг ажил гүйлгээ бөгөөд байгууллагын доорх ажил гүйлгээ хамаарна.

(а) гадаад валютаар үнэ нь илэрхийлэгдсэн бараа, үйлчилгээг худалдан авах, эсхүл худалдах;

(б) гадаад валютаар зээл авах, эсхүл олгох;

(в) дээр дурдсанаас бусад байдлаар гадаад валютаар илэрхийлэгдэх хөрөнгийг олж эзэмших, эсхүл данснаас хасах, өр төлбөр үүсгэх, эсхүл барагдуулах.

20.3.Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох Монголбанкны албан ханшаар хөрвүүлж, бүртгэлийн валютаар бүртгэнэ.

20.4.Төсөл, тусгай сан санхүүжилтийн орлогыг гадаад валютаар хүлээн авсан тохиолдолд орж ирсэн өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлж, бүртгэнэ.

20.5.Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг хүлээн авсан өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлж, бүртгэнэ.

20.6.Гадаад валютаарх ажил гүйлгээг дараах байдлаар бүртгэнэ:

(а) гадаад валютаарх авлагыг валютын ханш өссөн үед цуглуулсан:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт	Гадаад валютын ханшийн зөрүүний олз
Кт	Авлага /нэр төрлөөр/

(б) гадаад валютаарх авлагыг валютын ханш буурсан үед цуглуулсан:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Дт	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз
Кт	Авлага /нэр төрлөөр/

(в) гадаад валютаарх өглөгийг валютын ханш өссөн үед төлөхөд:

Дт	Өглөг /нэр төрлөөр/
Дт	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(г) гадаад валютаарх өглөгийг валютын ханш буурсан үед төлөхөд:

Дт	Өглөг /нэр төрлөөр/
Кт	Гадаад валютын ханшийн зөрүүний олз
Кт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс

20.7.Тайлант үеийн эцэст валютын ханштай холбоотой дараах тохируулгыг хийж, тайлагнана:

(а) гадаад валютаарх мөнгөн зүйлсийг тайлангийн өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлнэ.

(б) гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн Монголбанкны албан ханшийг ашиглан хөрвүүлнэ.

(в) гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжсэн мөнгөн бус зүйлсийг уг бодит үнэ цэнийг хэмжсэн өдрийн Монголбанкны албан ханшийг ашиглан хөрвүүлнэ.

20.8.Мөнгөн зүйлс нь гадаад валютаарх мөнгөн хөрөнгө болон гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өглөгөөс бүрдэнэ.

20.9.Мөнгөн зүйлсийн барагдуулалт, эсхүл мөнгөн зүйлсийн ханшийн өөрчлөлтөөс үүссэн зөрүүг тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(а) валютын ханш өссөн үед мөнгөн зүйлсийн хөрөнгийг нэмэгдүүлж, ханшийн зөрүүний олз бүртгэхэд:

Дт	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө – гадаад валют/ Авлага
Кт	Гадаад валютын ханшийн зөрүүний олз

(б) валютын ханш буурсан үед мөнгөн зүйлсийн өр төлбөрийг бууруулж, ханшийн зөрүүний олз бүртгэхэд:

Дт	Өглөг /нэр төрлөөр/
Кт	Гадаад валютын ханшийн зөрүүний олз

(в) валютын ханш буурсан үед мөнгөн зүйлсийн хөрөнгийг бууруулж, ханшийн зөрүүний гарз бүртгэхэд:

Дт Гадаад валютын ханшийн зөрүүний гарз
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө – гадаад валют/ Авлага

(г) валютын ханш буурсан үед мөнгөн зүйлсийн өр төлбөрийг нэмэгдүүлж, ханшийн зөрүүний гарз бүртгэхэд:

Дт Гадаад валютын ханшийн зөрүүний гарз
Кт Өглөг /нэр төрлөөр/

Толилуулгын валютын хөрвүүлэлт

20.10.Байгууллагын толилуулгын валют нь бүртгэлийн валютаас өөр бол тухайн байгууллага нь өөрийн санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлаа толилуулгын валютад хөрвүүлэх ба дараах горимыг ашиглана:

(а).толилуулсан санхүүгийн байдлын тайлан тус бүрийн хувьд хөрөнгө ба өр төлбөрийг тухайн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх Монголбанкны албан ханшаар хөрвүүлнэ.

(б).санхүүгийн үр дүнгийн тайлан тус бүрийн хувьд орлого, зардлыг тухайн ажил гүйлгээ гарсан өдрүүдийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлнэ.

(в).хөрвүүлэлтийн үр дүнд үүссэн ханшийн зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

20.11.Орлого, зардлын зүйлсийг хөрвүүлэхдээ тайлант үеийн дундаж ханшийг ашиглаж болно. Ханш ихээхэн хэлбэлзэлтэй байвал тухайн ажил гүйлгээ гарсан өдрүүдийн Монголбанкны албан ханшийг ашиглана.

20.12.Байгууллагын бүртгэлийн валют өөрчлөгдсөн тохиолдолд шинэ бүртгэлийн валютын хувьд хэрэглэх хөрвүүлэлтийн горимоо тухайн өөрчлөлтийн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө.

20.13.Төсөл, тусгай сангийн бүртгэлийн валют нь толилуулгын валютаас ялгаатай байгаа тохиолдолд дээрх аргачлалыг баримтална.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН БҮРТГЭЛ

21.1.Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн өр болон хүүг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэнэ.

21.2.Төслийн нэгж нь Монгол Улсын Засгийн газар, санхүүжүүлэгч байгууллага (олон улсын байгууллага, гадаадын улс орон) хооронд байгуулсан олон улсын гэрээний хүрээнд хүлээн авсан санхүүжилтийг орлогоор хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Санхүүжилтийн орлого

(а) төслийн нэгж нь гадаад зээл, тусламжаар хүлээн авсан мөнгөн хөрөнгийг санхүүжилтийн орлогоор, дамжуулагч банкны үйлчилгээний хураамжийн шимтгэлийг зардлаар бүртгэнэ:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Дт Банкны үйлчилгээний хураамж
Кт Гадаадын эх үүсвэрийн санхүүжилтийн орлого

(б) олон улсын зээл, тусламжийн гэрээний заалтын дагуу Монгол Улсын Засгийн газар, холбогдох төрийн байгууллагаас үзүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнгээр төслийн нэгж нь:

Дт Хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн орлого

21.3.Гадаад зээлийн ашиглалтын хэлбэрээс шалтгаалан холбогдох нягтлан бодох бүртгэлийг дараах гурван хувилбарын аль нэгээр хийнэ:

21.3.1.Төслийн нэгжийн данснаас төлбөр хийх. Засгийн газар гадаад зээл, тусламжийг гаднын зээлдүүлэгчээс мөнгөн хөрөнгөөр хүлээн авч, төслийн нэгжийн Төрийн сан дахь харилцах дансанд шилжүүлээд, тэр данснаас гүйцэтгэгч байгууллагад холбогдох төлбөрийг хийнэ.

(а) санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь зээлийн санхүүжилт орсон өдрөөр Монголбанкны албан ханшаар хөрвүүлэн, зээлийн өрийг төгрөгөөр бүртгэнэ.

Дт Гадаадын төслийн зээлээс санхүүжих
Кт Зээлийн өр

(б) төслийн нэгж нь гадаад зээл, тусламжийн санхүүжилтийг хүлээн авсан өдрөөр орлогыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Гадаадын эх үүсвэрийн санхүүжилтийн орлого

(в) төслийн нэгж нь зарцуулалтыг бүртгэх үед:

Дт Хөрөнгө /нэр төрлөөр/, эсхүл Зардал /нэр төрлөөр/
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Төслийн нэгж нь үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, биологийн хөрөнгө бүтээн бий болгож байгаа бол энэ журмын 10, 11, 12 дугаар бүлэгт заасны дагуу бүртгэнэ.

(г) гадаад улсын засгийн газрын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр хаагдах үед буцаан төвлөрүүлсэн зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг төслийн нэгж нь урсгал шилжүүлгийн зардлаар бүртгэнэ:

Дт Зарцуулагдаагүй үлдэгдлийн буцаалт
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(д) санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүртгэсэн “Гадаад эх үүсвэрээс санхүүжих” гэсэн зардлын дансны дүн болон төслийн нэгжийн “Гадаадын эх үүсвэрийн санхүүжилтийн орлого” гэсэн дансны дүн нь хоорондоо тэнцүү байна. Тайлант үеийн эцэст эдгээр дансыг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хооронд нь устгах бичилт хийнэ.

21.3.2.Шууд төлбөр. Засгийн газар гадаадын зээл, тусламжийг гаднын зээлдүүлэгчээс мөнгөн хөрөнгөөр хүлээн авч, холбогдох төлбөрийг гүйцэтгэгч байгууллагад шууд шилжүүлнэ.

(а) санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь зээлийн санхүүжилт орсон өдрөөр Монголбанкны ханшаар хөрвүүлэн, зээлийн өрийг төгрөгөөр бүртгэнэ.

Дт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө
Кт Зээлийн өр

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төлбөрийг гүйцэтгэх үед:

Дт Гадаад төслийн зээлээс санхүүжих
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Хэрэв төлбөрийг гадаад валютаар гүйцэтгэх үед зээлийн санхүүжилт орсон өдрийн ханш ба төлбөр хийсэн өдрийн ханшийн зөрүүгээр олз үүссэн бол:

Дт Гадаад төслийн зээлээс санхүүжих
Кт Гадаад валютын ханшийн зөрүүний олз
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Хэрэв төлбөрийг гадаад валютаар гүйцэтгэх үед зээлийн санхүүжилт орсон өдрийн ханш ба төлбөр хийсэн өдрийн ханшийн зөрүүгээр гарз үүссэн бол:

Дт Гадаад төслийн зээлээс санхүүжих
Дт Гадаад валютын ханшийн зөрүүний гарз
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(б) төслийн нэгж нь гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн ажлын гүйцэтгэлийн дүнгээр холбогдох хөрөнгө, эсхүл зардал хүлээн зөвшөөрнө:

Дт Хөрөнгө /нэр төрлөөр/, эсхүл Зардал /нэр төрлөөр/
Кт Гадаадын эх үүсвэрийн санхүүжилтийн орлого

21.3.3.Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт. Засгийн газар гэрээнд тохиролцсон нөхцөлийн дагуу гадаад дахь зээлдүүлэгчийн харилцах данснаас Засгийн газрын харилцах дансаар дамжихгүй шууд гадаад бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчийн харилцах дансанд төлбөр хийгдэж, төслийн нэгж хөрөнгийг хүлээн авна. Энэ тохиолдолд зээлийн мэдэгдлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх үед өр үүсгэнэ.

(а) санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэдэгдэл хүлээн авсан өдрөөр зээлийн өрийг Монголбанкны ханшаар хөрвүүлэн төгрөгөөр бүртгэнэ.

Дт Гадаад төслийн зээлээс санхүүжих
Дт Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз
Дт Үйлчилгээний хураамж / шимтгэл зардал
Кт Зээлийн өр

(б) төслийн нэгж нь мэдэгдэл хүлээн авсан өдрөөр зээлийн өрийн дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

Дт Урьдчилж төлсөн тооцоо /нэр төрлөөр/
Кт Гадаадын эх үүсвэрийн санхүүжилтийн орлого

(в) төслийн нэгж нь хөрөнгө (зөвлөх үйлчилгээ)-ийг хүлээн авсан өдрөөр холбогдох хөрөнгө болон зардлыг бүртгэнэ:

Дт Хөрөнгө /нэр төрлөөр/, Зардал /нэр төрлөөр/
Кт Урьдчилж төлсөн тооцоо /нэр төрлөөр/

21.4.Гадаадын зээл, тусламжаар бий болж буй хөрөнгийг захиалагч байгууллага барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.

(а) захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлыг бүртгэх үед:

Дт Үндсэн хөрөнгө /нэр төрлөөр/
Кт Хөрөнгийн тусламжийн орлого

(б) захиалагч байгууллага нь тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр хөрөнгө бүртгэх үед:

Дт Бусад санхүүгийн бус хөрөнгө
Кт Хөрөнгийн тусламжийн орлого

21.5.Засгийн газрын зээлтэй холбогдуулан гарч буй хүү болон капиталжуулсан хүүгийн зардлыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж, тайлагнана. Харин төслийн нэгж нь зээлийн ашиглалтын тооцоог нийлэхдээ ашиглалт, хөрөнгөжүүлсэн хүүгийн дүнг тооцоо нийлсэн акт дээр тусад нь тодорхойлон, шаардлагатай үед санхүүгийн тайланд тайлбар, тэмдэглэл хийнэ.

(а) санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад зээлийн хүүг хуримтлуулан бүртгэх үед:

Дт Хүүгийн зардал
Кт Хүүгийн өглөг

(б) гадаад зээлийг хүүг төлөх үед.

Дт Хүүгийн өглөг
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

(в) төслийн зээлүүдийн капиталжуулсан хүүгийн зардлыг бүртгэхдээ хүүгийн өглөгийн дансаар дамжуулах бол:

Дт Хүүгийн зардал
Кт Хүүгийн өглөг

Дт Хүүгийн өглөг
Кт Гадаад эх үүсвэрийн санхүүжилтийн орлого

Хүүгийн өглөгийн дансаар дамжуулаагүй үед:

Дт Хүүгийн зардал
Кт Гадаад эх үүсвэрийн санхүүжилтийн орлого

Зээлийн өр төлбөр

21.6.Засгийн газрын гадаад зээллэгийн өглөгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж, харин төслийн нэгж бүртгэж, тайлагнахгүй.

21.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь зээл авсан өдрөөр зээлийн өрийг бүртгэх үед:

Дт Гадаад эх үүсвэрээс санхүүжих
Кт Зээлийн өр

21.8. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дамжуулан зээлдүүлэх гэрээг хуулийн этгээдтэй байгуулах бөгөөд тухайн гэрээний дагуу дамжуулан зээлийн өрийг бүртгэнэ. Зээлийн гэрээ байгуулаагүй тохиолдолд бүртгэлд тусгахгүй. Төслийн нэгж тухайн байгууллагатай хоорондын тооцоо үүсгэж, тооцоо нийлэх ба харин зээлийн өглөгийг бүртгэхгүй.

21.9.Олон улсын байгууллага, түнш орноос авсан гадаад зээлийг дотоодын зээлдэгчид дамжуулан зээлдүүлэх үед Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага авлага бүртгэнэ:

Дт Зээлийн авлага
Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

21.10.Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний хүрээнд зээл авч буй хуулийн этгээд нь төслийн тусдаа нэгжийг байгуулалгүй, өөрөө хариуцан ажиллаж байгаа тохиолдолд төслийн нэгжийн үйл ажиллагааны тайланг энэ журамд заасны дагуу тусад нь бүртгэж, сегментийн тайлан бэлтгэж, тайлагнана.

21.11.Гадаад зээл, тусламжтай холбоотой гадаад валютын бүртгэл, тайлагналыг энэ журмын 20 дугаар бүлэгт заасны дагуу хийнэ.

~ o0o ~

*“Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан
бодох бүртгэлийн журам”-ын нэгдүгээр хавсралт*

САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТОДРУУЛГА БЭЛТГЭХ ЗААВАР

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1.Төсвийн байгууллага нь нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэхэд энэ зааврыг мөрдөнө.

1.2.Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.

1.3.Төсвийн байгууллага нь тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

2.1.Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь нөөцийн хуваарилалтын талаарх шийдвэрийн үнэлгээ ба шийдвэр гаргахад хэрэглэгчдэд ач холбогдолтой уг байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тухай мэдээллээр хангах явдал юм.

2.2.Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

- (а) санхүүгийн үр дүнгийн тайлан;
- (б) санхүүгийн байдлын тайлан;
- (в) мөнгөн гүйлгээний тайлан;
- (г) цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;
- (д) санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тодруулга;
- (е) төсвийн гүйцэтгэлийн тайлан.

2.3.Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгах мэдээлэл нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэх боломжтой байх, шалгах боломжтой байх зэрэг чанарын шинжүүдийг хангана.

2.4.Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэхэд дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд:

(а) төсвийн байгууллагын санхүүгийн тайланг аккрузл суурьт УСНББОУС-д нийцүүлэн бэлтгэнэ.

(б) санхүүгийн тайланд төсвийн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, нэмэлт тайлбар, тодруулгыг үнэн зөв толилуулна.

(в) байгууллагыг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй байх сууриар бэлтгэнэ.

(г) санхүүгийн тайлан дахь толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгална.

(д) санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулна. Материаллаг бус дүнтэй зүйлсийг шинж чанар буюу үүргийнх нь дагуу ижил зүйлсийн дүнтэй нэгтгэн толилуулна.

(е) байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох тайлангийн маягтын дагуу өмнөх үеийн мэдээлэлтэй зэрэгцүүлсэн байдлаар толилуулна.

(ё) энэ заавар болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартаар цэвэр дүнг гаргахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрөнгө, өр төлбөр болон орлого, зардлыг цэвэр дүнгээр тайлагнахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

3.1. Санхүүгийн үр дүнгийн тайлан нь төсвийн байгууллагын тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнг тооцож, толилуулна.

3.2. Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг хүлээн авсан, эсхүл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Шилжүүлэг болон бусад зардлыг бодитоор гарсан хэмжээгээр нь тусгана. Энэхүү тайланд зардлыг чиг үүргээр нь ангилж үр дүнг тооцно.

3.3. Санхүүгийн үр дүнгийн тайланг бэлтгэхдээ тухайн тайлант үеийн орлого, зардлын ажил гүйлгээг аккрузал сууриар бүртгэнэ.

3.4. Орлого, зардал, олз, гарзыг тэдгээрийн үүсэн гарч буй шинж төрлөөр нь ангилна. Зардлын зүйл ангийг холбогдох орлогын зүйл ангитай уялдуулан зохицох зарчмын дагуу хүлээн зөвшөөрнө.

3.5. Төсвийн байгууллага нь тайлант үеийн үр дүн түүнчлэн, цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн олз, гарз нэг бүрийг тухайн хяналт тавигч байгууллага болон хяналтын бус хувь оролцоонд хамааруулан хуваарилна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

4.1. Санхүүгийн байдлын тайлан нь төсвийн байгууллагын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн үлдэгдлийг тайлагналын өдрөөр тасалбар болгон толилуулна.

(а) хөрөнгө гэж байгууллагын хяналтад байгаа, өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсэж, ирээдүйд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавх бий болгох нөөцийг хэлнэ.

(б) өр төлбөр гэж эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавх бүхий нөөцийн гадагшлах урсгалаар төлөгдөхөөр хүлээгдэж буй өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд үүссэн байгууллагын одоогийн үүрэг хариуцлагыг хэлнэ.

(в) цэвэр хөрөнгө/өмч гэж нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгийг хэлнэ.

(г) хяналтын бус хувь оролцоо гэдэг нь хяналт тавигч байгууллагад шууд болон шууд бусаар үл хамаарах хяналтад буй байгууллага дахь цэвэр хөрөнгө/өмч юм.

4.2. Байгууллага санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө ба өр төлбөрийг шинж чанар, хөрвөх чадвараар жагсааж, толилуулна.

4.3. Байгууллага нь хяналтын бус хувь оролцоог санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хяналтын хувь оролцооны цэвэр хөрөнгө/өмчөөс тусад нь толилуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

5.1. Мөнгөн гүйлгээний тайлан нь үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ, нийт цэвэр мөнгөн гүйлгээ гэсэн хэсгээс бүрдэнэ.

5.2. Төсвийн байгууллага нь мөнгөн гүйлгээний тайланг шууд аргаар бэлтгэнэ.

5.3. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой гарсан мөнгөн гүйлгээг харуулна.

(а) үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогод:

- Татварын орлого
- Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого
- Тусламж, шилжүүлгийн орлого
- Бусад мөнгөн орлого

(б) үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:

- Цалин хөлс, нийгмийн даатгалын зардал
- Бараа материалын зардал
- Ажил, үйлчилгээний зардал
- Хүүгийн зардал
- Татаас
- Урсгал шилжүүлэг
- Нийгмийн хамгааллын шилжүүлэг
- Бусад мөнгөн зарлага

(в) үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно.

5.4. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь урт хугацаанд ашиглагдах хөрөнгө болон бусад хөрөнгө оруулалтыг олж эзэмших болон данснаас хасах ажил гүйлгээг харуулна.

(а) хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлогод:

- Үндсэн хөрөнгө борлуулсны орлого
- Биет бус хөрөнгө борлуулсны орлого
- Хөрөнгө оруулалт борлуулсны орлого
- Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт
- Бусад мөнгөн орлого

(б) хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлагад:

- Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн
- Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн
- Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн
- Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа
- Бусад мөнгөн зарлага

(в) хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.

5.5.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь урт хугацаат өр төлбөр болон цэвэр хөрөнгө/өмчид гарсан өөрчлөлтийн үр дүнд бий болсон ажил гүйлгээг харуулна.

(а) санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогод:

- Гадаад зээлээс хүлээн авсан мөнгөн орлого
- Дотоод зээлээс хүлээн авсан мөнгөн орлого
- Бусад мөнгөн орлого

(б) санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:

- Гадаад зээл төлбөр төлсөн
- Дотоод зээл төлбөр төлсөн
- Ногдол ашиг болон адилтгах хуваарилалт
- Бусад мөнгөн зарлага

(в) санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.

5.6.Нийт цэвэр мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр тодорхойлно.

5.7. Нийт цэвэр мөнгөн гүйлгээ нь тайлант үеийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдлийг хасаж тооцсон мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өөрчлөлтийн дүнтэй тэнцүү байна.

5.8.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдлийг гадаад валютаар илэрхийлэгдсэн дүнгийн ханшийн өөрчлөлтөөр тохируулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

6.1.Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан нь төсвийн байгууллагын цэвэр хөрөнгө буюу өмчид гарсан аливаа өөрчлөлтийг толилуулна.

6.2.Засгийн газрын оруулсан хөрөнгө, хуримтлагдсан үр дүн болон бусад нөөц зэрэг өмчийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хувьд тайлант үеийн эхний, эцсийн үлдэгдэл, тухайн тайлант үед гарсан өөрчлөлтийг тусад нь харуулна.

6.3.Цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдлийг нэмэгдсэн болон хасагдсан өөрчлөлтөөр тохируулж, эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

6.4.Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааг хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг залруулж тусгана.

6.5.Хуримтлагдсан үр дүнгийн залруулсан үлдэгдэл дээр тайлант үеийн санхүүгийн үр дүнг нэмж, ногдол ашиг, түүнтэй адилтгах хуваарилалтыг хасаж, эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

6.6.Хяналтын бус хувь оролцооны эзэмшиж буй хувь хэмжээ өөрчлөгдсөн үед байгууллага нь хяналтын болон хяналтын бус хувь оролцооны дансны үнийг тохируулна.

6.7.Байгууллага нь хяналтын бус хувь оролцоог тохируулсан дүн ба төлсөн төлбөрийн бодит үнэ цэнэ хоорондох аливаа зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх бөгөөд түүнийг тухайн хяналт тавигч байгууллагад хамааруулан хуваарилна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

7.1.Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь тайлант үеийн үр дүнг батлагдсан төсвийн мэдээлэлтэй зэрэгцүүлэн толилуулна.

7.2.Холбогдох бусад заавар журам болон УСНББОУС 24 *Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга*-ын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

8.1.Төсвийн байгууллага нь санхүүгийн тайлангийн бэлтгэлтийн суурь болон ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх мэдээллийг тодруулна.

8.2.Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч УСНББОУС-уудаар шаарддаг мэдээллийг тодруулна.

